

2026 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөө

АГУУЛГА

Бүлэг 1. Төслийн товч танилцуулга	3
1.1.Төслийн талаарх мэдээлэл	3
Бүлэг 2. Төсөл хэрэгжиж буй нутгийн байгаль орчин, нийгэм-эдийн засгийн төлөв байдлын товч танилцуулга	20
2.1. Уур амьсгал өнөөгийн төлөв байдал	20
2.2. Газрын гадарга, хэвлий өнөөгийн төлөв байдал	20
2.3. Төслийн талбайн гадаргын болон газрын доорх усны төлөв байдал.....	20
2.4. Хөрсөн бүрхэвч өнөөгийн төлөв байдал.....	21
2.5. Ургамлан бүрхэвч өнөөгийн төлөв байдал	22
2.6. Төслийн талбай орчмын амьтны аймаг	23
2.7.Нийгэм, эдийн засаг өнөөгийн төлөв байдал:	24
Бүлэг 3. Төслийн гол ба болзошгүй сөрөг нөлөөллийн товч тодорхойлолт	25
3.1 Төслийн үйл ажиллагаанаас агаарын чанарт үзүүлж болзошгүй гол сөрөг нөлөөлөл	25
3.2. Газрын гадарга, хэвлий, хөрсөн бүрхэвчид үзүүлж болзошгүй нөлөөлөл	25
3.3. Гадаргын болон газрын доорх усанд үзүүлж болзошгүй гол сөрөг нөлөөлөл	25
3.4. Ургамлан бүрхэвчид, амьтны аймагт үзүүлж болзошгүй гол сөрөг нөлөөлөл	26
3.5. Нийгэм эдийн засагт үзүүлж болзошгүй нөлөөлөл.....	26
Бүлэг 4. Байгаль орчны менежментийн тухайн жилийн төлөвлөгөөний гол зорилт, хамрах хүрээ.....	28
Бүлэг 5. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө	29
Бүлэг 6. Ногоон байгууламж, тэрбум модны хөтөлбөрийн төлөвлөгөө	33
Бүлэг 7. Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах, тэрбум мод хөтөлбөрийн арга хэмжээний төлөвлөгөө	34
7.1. Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээ.....	34
Бүлэг 8. Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөө	36
Бүлэг 9. Түүх соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө.....	36
Бүлэг 10. Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө	37
Бүлэг 11. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө.....	38
11.1. Хог хаягдлыг бууруулах, дахин ашиглах, боловсруулах	38
11.2. Хог хаягдлын тооцоо, судалгаа	39
Бүлэг 12. Химийн бодисын эрсдэлийн менежментийн төлөвлөгөө	43
Бүлэг 13. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр.....	43
Бүлэг 14. Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө.....	47
Бүлэг 15. Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг нөлөөлөлд өртөгч оршин суугчид, оролцогч талуудад тайлагнах хуваарь.....	48
Байгаль орчны менежментийн 2026 оны төлөвлөгөөний нэгдсэн төсөв, дүгнэлт	49

2026 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөө

Хүснэгтийн жагсаалт

Хүснэгт 1. Хайлуур жоншны баяжуулах үйлдвэрийн газар зүйн солбицлууд	5
Хүснэгт 2. Бүтээгдэхүүн гаргалтын төлөвлөгөө	10
Хүснэгт 3. Баяжуулах үйлдвэрт хэрэглэгдэх тоног төхөөрөмж	11
Хүснэгт 4. Баяжуулах үйлдвэрийн усны зарцуулалтын тооцоо	14
Хүснэгт 5. Баяжуулах үйлдвэрийн ажилчдын орон тоо	14
Хүснэгт 6. Шинжилгээний лабораторид хэрэглэгдэх тоног төхөөрөмж	17
Хүснэгт 7. Механик цехийн нийт тоног төхөөрөмж	17
Хүснэгт 8. Гэнэтийн аюул ослын үед зохицуулах төрийн байгууллагууд	18
Хүснэгт 9. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө	30
Хүснэгт 10. Тэрбум мод хөтөлбөрийн хүрээнд зарцуулах ажлын 5 жилийн төлөвлөгөө зардал	33
Хүснэгт 12. Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө	37
Хүснэгт 13. Төслийн үйл ажиллагаанаас гарах хатуу хог хаягдал сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх зорилгоор хог хаягдлыг ангилан ялгана.	39
Хүснэгт 14. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө	41
Хүснэгт 15. 2026 онд хэрэгжүүлэх орчны хяналт шинжилгээний хөтөлбөр	44
Хүснэгт 16. Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө	47
Хүснэгт 17. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг тайлагнах хуваарь, зардлын задаргаа	48
Хүснэгт 18. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний нэгдсэн хүснэгт	52

Зургийн жагсаалт

Зураг 1. “Говь аргатай девелопмент” ХХК-ийн баяжуулах үйлдвэрийн байршлын зураг	4
Зураг 2. Үйлдвэрийн зураг	7
Зураг 3. Ажилчдын байрны харагдах байдал	7
Зураг 4. Баяжуулах үйлдвэрийн харагдах байдал	9
Зураг 5. Баяжуулах үйлдвэрийн технологийн схем	10
Зураг 6. Баяжуулах үйлдвэрт хэрэглэгдэх тоног төхөөрөмжийн техникийн үзүүлэлт	11
Зураг 7. Усны хайгуул хийж буй зураг /2020.05.05/	13
Зураг 8. Усны хайгуул хийж буй зураг /2020.05.05/	14
Зураг 9. Ажилчдын байр болон оффисын төлөвлөлтийн зураг	16
Зураг 10. Үйлдвэрийн дотоод цахилгаан хангамжийн схем	18
Зураг 13. Хог хаягдлын менежментийн зарчим	38
Зураг 14. Орчны хяналт шинжилгээ авах цэгийн байршил	46

Бүлэг 1. Төслийн товч танилцуулга


1.1.ТӨСЛИЙН ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ

Төсөл хэрэгжүүлэгч: “Говь аргатай девелопмент” ХХК Регистрийн дугаар 3433668; Улсын бүртгэлийн дугаар: 0811004095, Хаяг: Дундговь аймаг, Баянжаргалан сум, 3-р баг, Аргатай, Дөш 1-4 тоот

Утас: 88113273, 99083273.

Төслийн нэр: “Хайлуур жоншны хүдрийг гравитацын аргаар баяжуулах үйлдвэр байгуулах”

Төслийн байршил: “Говь аргатай девелопмент” ХХК-ийн хайлуур жоншны хүдрийг гравитацын аргаар баяжуулах үйлдвэр нь Дундговь аймгийн Баянжаргалан сумын нутаг дэвсгэрт орших ба Баянжаргалан сумын төвөөс зүүн урагш 2.5 км, Мандалговь хотоос зүүн тийш 153 км, Улаанбаатар хотоос зүүн урагш 315 км зайтай төмөр замын дагуу дэд бүтэц сайн хөгжсөн (цахилгаан эрчим хүч, төмөр зам, авто зам, газрын гүний усны нөөц) бүс нутагт 4.0 га талбайг хамран оршино. (Зураг 1).



Зураг 1. “ГОВЬ АРГАТАЙ ДЕВЕЛОПМЕНТ” ХХК-ийн БАЯЖУУЛАХ ҮЙЛДВЭРИЙН БАЙРШЛЫН ЗУРАГ

2026 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөө

Хүснэгт 1. Хайлуур жоншны баяжуулах үйлдвэрийн газар зүйн солбицлууд

№	Уртраг	Өргөрөг
1	45°44'53.62"	108°01'35.05"
2	45°44'49.72"	108°01'42.42"
3	45°44'44.37"	108°01'37.15"
4	45°44'48.3"	108°01'29.8"

Хайлуур жоншны хүдрийг гравитацын аргаар баяжуулах ТЭЗҮ-ийг 2020 оны 6-р сард ЭБМЗ-өөр хэлэлцүүлэн батлуулж, 2024 онд улсын комисст хүлээлгэн өгсөн. 2025 оноос үйл ажиллагаа эхлүүлэхээр төлөвлөж байна.


2020-2021 онд төслийн талбайд усан хангамжийг бүрэн шийдсэн ба 2 цэгт худаг өрөмдөж паспорт аваад байна. 2023 онд үйлдвэрийн барилга угсралт, тоног төхөөрөмжийн угсралт суурилуулалтыг ажлыг гүйцэтгэж, үйлдвэрийг асаан жигдрүүлж ажиллуулахад бэлэн болсон.

“Говь аргатай девелопмент” ХХК нь баяжуулах үйлдвэрийн барилга байгууламжуудад:

- БҮ-ийн сэндвичид барилга
- Дэд станц
- Сэлбэг, материалын агуулах
- Ажилчдын байр
- Гал тогоо
- Автомашины граш
- Харуулын байр зэрэг орно.

Баяжуулах үйлдвэр нь дараах хэсгүүдээс бүрдэнэ. Үүнд:

- Анхдагч хүдэр буулгах талбай
- Бутлан ангилах хэсэг
- Хаягдлын овоолгын хэсэг
- Баяжмал савлах, хадгалах хэсэг
- Авто пүүний хэсэг
- Цахилгаан хангамжийн хэсэг
- Хяналтын лаборатори
- Засвар, сэлбэгийн газар
- Захиргаа, ажилчдын байр
- Баяжуулах үйлдвэр орчмын зам



ЗУРАГ 2. ҮЙЛДВЭРИЙН ЗУРАГ



ЗУРАГ 3. АЖИЛЧДЫН БАЙРНЫ ХАРАГДАХ БАЙДАЛ





Зураг 4. БАЯЖУУЛАХ ҮЙЛДВЭРИЙН ХАРАГДАХ БАЙДАЛ

Баяжуулах үйлдвэрийн түүхий эд хангамж-2026 он

Баяжуулах үйлдвэр нь 2026 онд “Улаан хад кристал майнинг” ХХК-ийн Дорноговь аймгийн Айраг сумын нутагт орших хайлуур жоншны MV-021094 тоот ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй ордоос 25%-ийн агуулгатай 40.0 мян.тн хүдэр худалдан авахаар төлөвлөсөн.

Гравитацын аргаар баяжуулах технологи

Баяжуулах үйлдвэр нь Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2019 оны 10 дугаар сарын 17-ны өдрийн А/205 дугаар тушаалаар батлагдсан “Баяжуулах үйлдвэрт тавигдах шаардлага, үйл ажиллагаа эрхлэх журам”-д нийцүүлэн үйл ажиллагааг эрхлэн явуулна. Үйлдвэрийг түүхий эдээр хангах хүдрийн баяжигдах судалгаа “Ханлаб” лабораторид хийгдсэн. Туршилтын үр дүнд үндэслэн ТЭЗҮ боловсруулсан ба 2026 онд уг баяжуулах үйлдвэрийг ажиллуулахаар бэлтгэл ажил хийгдэж байна. Үйлдвэрийн ерөнхий горимыг дор үзүүлэв.

Баяжуулах үйлдвэрийн бүтэц

Баяжуулах үйлдвэр нь түүхий эд буулган жигдрүүлэх талбай, хүдэр бутлан ангилах хэсэг, баяжуулах хэсэг, баяжмал савлах, хадгалах хэсэг, хаягдлын аж ахуй, засвар үйлчилгээний хэсэг, эргэлтийн усны сан, цэвэр усны худаг, ус дамжуулах насос, цахилгаан хангамжийн хэсэг, хяналтын лаборатори, уурын зуухны хэсэг, ажилчдын байр контор зэргээс бүрдэнэ.

Хүдэр бутлалт

Жонш олборлогчоос нийлүүлж буй түүхий эдийг баяжуулах үйлдвэрийн дэргэдэх хүдэр жигдрүүлэх талбайд зөөвөрлөн авчирч, жоншны агуулга болон хүдэр дэх карбонатын агуулгаас хамааруулан үечлэн овоолго байгуулах замаар хүдрийг жигдрүүлэн баяжуулахад бэлтгэн хадгална. Хүдрийг холих үедээ хүдрийн бүтцийн чанарыг судлах шаардлагатай.

Хүдэр баяжуулалт


Бутлан ангилах хэсгээс гарах 8-20 мм, 20-40 мм-ийн ширхэглэлтэй ангилсан хүдрийг гравитацийн аргаар тунаах машинд баяжуулан ФГ-85 маркийн хайлуур жоншны баяжмал үйлдвэрлэх ба, технологиос гарах 0-8 мм-ийн ширхэглэлтэй 25.39 %-ийн хайлуур жоншны агуулгатай хүдрийг үйлдвэрээс 500 метр зайд байрлах флотацаар БҮ-т (“Болор жонш” ХХК) худалдана. 8-20 мм болон 20-40мм-ийн ширхэглэлтэй хүдрийг тус тусад нь 1 шатны тунаах машинд баяжуулах ба үйлдвэрлэсэн ФГ-85маркийн хайлуур жоншны баяжмалыг экспортод гаргана. Тунаахаас гарч буй 7.6 %-ийн хайлуур жоншны агуулгатай хаягдлыг хаягдлын овоолгод байршуулна.

Баяжмал савлах, хадгалах хэсэг

Тунаан машинаас гарсан баяжмалыг тээвэрлэн савлах бункерт оруулна. 2 тонны уутанд баяжмалыг савлан, баяжмал хадгалах агуулахад хадгална. Савлагдсан баяжмалын уутан дээр

2026 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөө

үйлдвэрлэсэн улс, баяжмалын жин, ачигдах орны нэр, хаягийг бичиж тээвэрлэн гадаад зах зээлд гарган борлуулна.



Зураг 5. БАЯЖУУЛАХ ҮЙЛДВЭРИЙН ТЕХНОЛОГИЙН СХЕМ


ХҮСНЭГТ 2. БҮТЭЭГДЭХҮҮН ГАРГАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

№	Үзүүлэлтүүд	Нэгж	1-р жил
Хүдэр Баяжуулалт			
1	Худалдан авах хүдрийн хэмжээ	тн	40000
2	Хүдэр дэх жоншны агуулга	%	25.0
3	Хүдэр дэх жоншны хэмжээ	тн	10000
ФГ-85 баяжмал			
4	Баяжмалын агуулга	%	85.05
5	Баяжмалын минерал авалт	%	59.82
6	Баяжмалын гарц	%	17.58
7	Баяжмалын хэмжээ	тн	7033.13
8	Баяжмал дахь жоншны хэмжээ	тн	5981.73
Завсрын бүтээгдэхүүн (0-8 мм)			
9	Зав.бүтээгдэхүүний агуулга	%	24

2026 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөө

10	Зав.бүтээгдэхүүний минерал авалт	%	42.46
11	Зав.бүтээгдэхүүний гарц	%	55.18
12	Зав.бүтээгдэхүүний хэмжээ	тн	22073.04
13	Зав.бүтээгдэхүүн дэх жоншны хэмжээ	тн	5604.34
Хаягдал			
14	Хаягдлын агуулга	%	7.58
15	Хаягдлын минерал алдалт	%	5.66
16	Хаягдлын гарц	%	24.65
17	Хаягдлын хэмжээ	тн	9860.3
18	Хаягдал дахь жоншны хэмжээ	тн	747.4

Баяжуулах үйлдвэрт хэрэглэгдэх тоног төхөөрөмжийн техникийн үзүүлэлт



ЗУРАГ 6. БАЯЖУУЛАХ ҮЙЛДВЭРТ ХЭРЭГЛЭГДЭХ ТОНОГ ТӨХӨӨРӨМЖИЙН ТЕХНИКИЙН ҮЗҮҮЛЭЛТ

/1-Утгуурт ачигч, 2, 13,15-Бункер, 3, 14,16-Тэжээгүүр, 4-Хацарт бутлуур, 5, 7, 8, 10, 11, 12-Туузан дамжуулагч, 6, 9-Шигшүүр, 17-Тунаах машин

ХҮСНЭГТ 3. БАЯЖУУЛАХ ҮЙЛДВЭРТ ХЭРЭГЛЭГДЭХ ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ

№	Тоног төхөөрөмжийн нэр	Марк	Ажиллах тоо, ш	Суурь чадал /кВт/	Нийт чадал /кВт/
---	------------------------	------	----------------	-------------------	------------------

2026 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөө

1	Чичиргээд тэжээгүүр	GZD 650*2300	2	15.00	30
2	Туузан дамжуулагч	B-500	8	5.5	44
3	Чичиргээд шигшүүр	SZZ1250*2500	1	18.5	18.5
4	Хацарт бутлуур	PE400*600	2	30	30
5	Чичиргээд шигшүүр	SZZ900*1800	1	5.55.5	5.5
6	Тунаах машин	JT4-2	2	7.5	15
7	Баяжмалын шигшүүр	2YD1237	1	11	11
8	Эргэлтийн усны насос	2/1.2B-AH	2	5.5	11
9	Цэвэр усны насос	35QV-SP	1	15	15
10	Тоосны циклон	ЦН-10	1	2.5	2.5
11	Утгуурт ачигч	SEM 650B	1	-	-
12	Сэрээт ачигч	CPD25B	1	-	-
	Нийт		19		168.2

Усан хангамж

“Говь аргатай девелопмент” ХХК-ийн захиалгын дагуу “Хүрд-Ус” ХХК нь 2019 онд 1980-аад онд бэлчээрийн талбайн ус хангамжид зориулан өрөмдсөн өрөмдмөл худгийг засварлах ажлыг хийсэн. Уг худагт их засварын ажил хийж ашиглалтад бэлтгээд цахилгаан насосоор шавхалт хийж үзэхэд ундарга 2.5 л/сек байна. Усны нөөцийн судалгааны хайгуулын өрөмдлөгийн ажил хийгдэж 3 цэгт өрөмдөж усны нөөцийг урьдчилан байдлаар хийн шавхалтын ажил хийгдсэн.



Зураг 7. Усны хайгуул хийж буй зураг /2020.05.05/



2026 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөө

ЗУРАГ 8. УСНЫ ХАЙГУУЛ ХИЙЖ БУЙ ЗУРАГ /2020.05.05/

Баянжаргалан сумын 3 багийн Говь-Аргатай девеломент ХХК үйлдвэрийн талбайд өрөмдсөн гидрогеологийн хайгуул судалгааны өрөмдлөгийн ажлын журналаас харахад делюви, пролювийн сэвсгэр хурдас 20 м орчим түүнээс доош гүний чулуулаг тархсан байна. Сэвсгэр хурдас нь бор өнгийн шороо хайр, дайрга зэргээс бүрдэх ба ул чулуулаг нь брекчи, андезит, хар өнгийн занар зэргээс тогтоно. Гидрогеологийн энгийн нөхцөлтэй усны химийн найрлагын хувьд эрдэсжилт өндөртэй 1-3 г/л ус нь химийн найрлагаараа гидрокарбонат, кальци, магни зонхилсон байна.

ХҮСНЭГТ 4.БАЯЖУУЛАХ ҮЙЛДВЭРИЙН УСНЫ ЗАРЦУУЛАЛТЫН ТООЦОО

№	Үзүүлэлтүүд	Хэмжих нэгж	Тоо хэмжээ
1	Баяжуулах үйлдвэрийн технологийн усны хэрэглээ	м ³ /цаг	47.4
2	Цэвэршүүлэн буцаан ашиглах усны хэрэглээ	м ³ /цаг	36.0
3	Баяжуулах үйлдвэрийн эргэлтийн усны дахин ашиглалт	%	75.95
4	1 тн хүдэр баяжуулахад хэрэглэгдэх усны хэмжээ	м ³ /цаг	2.5
5	Жилд хэрэглэх нийт усны хэмжээ	мян.м ³ /жил	33.42
6	Жилд хэрэглэх эргэлтийн усны хэмжээ	мян.м ³ /жил	25.4
7	Шинээр зарцуулах цэвэр усны хэмжээ	м ³ /цаг	11.40
8		м ³ /хоног	42.3
9		мян.м ³ /жил	8.0
10	Баяжуулах үйлдвэрийн хэрэгцээтэй усны ундарга	л/сек	3.2

Эргэлтийн усны хангамж нь технологийн ус, тоос дарах болон бусад шаардлагатай усны хэрэглээг хангах бөгөөд эргэлтийн усны сан, ус дамжуулах хоолой, даралтын насос зэргээс бүрдэнэ. Эргэлтийн ус дамжуулах насосын станцын гарах аманд урсцын хэмжээ, даралтыг шалгах хэмжүүр суурилуулна. Баяжуулах үйлдвэрийн төв байр доторх баяжуулах ба бусад дамжлагад мөн дээрх хэмжих багажийг тохируулж хяналтын өрөөнөөс системийн ажлын байдал болон усны зарцуулалтад хяналт тавина.

Баяжуулах үйлдвэрийн технологийн горимын дагуу шаардлагатай тоног төхөөрөмжүүдийг хөргөх зорилгоор цэвэр усны сангаас тоног төхөөрөмжийн хөргөлтийн усыг дамжуулна.

Ажиллах хүчний тооцоо

ХҮСНЭГТ 5. БАЯЖУУЛАХ ҮЙЛДВЭРИЙН АЖИЛЧДЫН ОРОН ТОО

№	Албан тушаал	Орон тоо
1	Захирал	1
2	Баяжуулах үйлдвэрийн дарга	1

2026 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөө


3	Ерөнхий инженер	1
4	Нягтлан бодогч	1
5	Нярав	1
6	Хүний нөөцийн ажилтан	1
7	Борлуулалтын менежер	1
8	Баяжуулагч инженер	2
9	Цахилгааны инженер	2
10	Хөдөлмөрийн эрүүл ахуй аюулгүй байдлын инженер	1
11	Бутлан ангилах хэсгийн оператор	2
12	Утгуурт ачигчийн оператор	1
13	Тунаах машины оператор	2
14	Туслах	2
15	Засварчин	2
16	Цахилгаанчин	1
17	Лаборант	1
18	Савлагч	2
19	Тогооч	3
20	Жолооч	3
21	Үйлчилгээний туслах ажилтан	4
22	Нийт ажиллагсдын тоо	35
23	Үүнээс гадаад ажилтны тоо	3
24	Гадаад ажилтны албан тушаал -Баяжуулагч инженер	1
25	-Тунаах машины оператор	2

Ажиллагсдын байр болон захиргаа

БҮ-ийн дэргэд үйлдвэрийн захиргаа, ажилчдын байр байрлах ба дотроо хоолны газар, амрах байр, халуун усны өрөө, амралтын өрөө, сургалтын танхим зэрэг багтана. БҮ-т нийт 35 орчим хүн ажиллах ба үйлдвэрийн ажиллах хүчний тоо болон дэд бүтцийн байршлаас хамааран үйлдвэр дээр байнгын эмч, сувилагч байх шаардлагагүй байна. Шаардлагатай үед Баянжаргалан сумын эрүүл мэндийн төвөөр үйлчлүүлэхээр төсөлд тусгасан.

БҮ-т ажиллагсдын 80% нь тухайн орон нутгийн ажилчдыг ажиллуулах учир суурин газар байрлан үйлдвэрийн гэрээт тээврийн хэрэгслээр тээвэрлэнэ. Үлдэх 20 % ажилчдын байранд байрлаж ажиллана.

2026 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөө



ЗУРАГ 9. АЖИЛЧДЫН БАЙР БОЛОН ОФФИСЫН ТӨЛӨВЛӨЛТИЙН ЗУРАГ

Хаягдлын аж ахуй

Хаягдлын тээвэрлэлт, хаягдлын сангийн тоног төхөөрөмжийн барилга байгууламж, эргэлтийн усан сангийн хангамж нь бүхэлдээ хаягдлын аж ахуйд хамаарна. “Говь аргатай девелопмент” хайлуур жоншны баяжуулах үйлдвэр нь хүдрийг ангилан -8+0 мм ангилалтай хүдрийг ойролцоо байх хайлуур жоншийг гравитацийн аргаар баяжуулах үйлдвэрт худалдаж, -20+8 мм, -40+20 мм-ийн ширхэглэлтэй хүдрийг тунаах машинд баяжуулна.

Тунаах машинаас 8-40 мм-ийн ширхэглэлтэй хаягдал гарах ба үүнийг хаягдлын санд өөрийн урсгалаар тунгаан эргэлтийн усыг дахин хэрэглэж хуурай хаягдлыг хаягдлын овоолго үүсгэнэ. Хаягдлын сангийн урт, өргөний хэмжээ 35х30м, гүн нь 1-2 м байна. Эргэлтийн усан сан нь 15х30х1 м хэмжээтэй 450 м³-ийн эзлэхүүнтэй байна.

Харин хуурай хаягдлын үйлдвэрээс 50 м зайд овоолго үүсгэхээр төлөвлөсөн. Барилгын ажлын дунд явцаас эхлэн хаягдлын далангийн байгуулалтын ажлыг гүйцэтгэнэ. Хаягдлын овоолгын талбай нь байгуулахдаа дараах нөхцөлүүдийг харгалзан авч үзсэн. Үүнд:

- Хүрээлэн буй байгаль орчин, олон нийтийн аюулгүй байдалд сөргөөр нөлөөлөхгүй байх
- Ашиглалтын үед болон хаалтын дараа тогтвортой байдлаа хадгалах
- Овоолгын налуугийн өнцгийн тогтвортой байдлыг хангах

Хүдэр баяжуулах технологи нь гравитацийн аргаар баяжуулах тул хаягдал нь химийн урвалж бодис агуулахгүй. Гадаргад ил гарсны дараа гадаргын усны нөлөөгөөр рН-ийн тэнцвэр нь алдагдахгүй тул гадаргын болон гүний усны шинж чанарт сөргөөр нөлөөлөхгүй.

2026 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөө

Хүснэгт 6. Шинжилгээний лабораторид хэрэглэгдэх тоног төхөөрөмж

№	Тоног төхөөрөмжийн нэр	Марк	Ажиллах тоо, ш	Цахилгаан зарцуулалт	
				Нэгж, кВт	Нийт, кВт
1	Хацарт бутлуур	PEX-100x125	1	1.1	1.1
2	Шигшүүрийн иж бүрдэл	HY-200	1	0.12	0.12
3	Шинжилгээний тусгай төхөөрөмж	GJ-AX	1	0.5	0.5
4	Хатаах зуух	RJM-2.8-10	1	1.1	1.1
5	Цахилгаан хатаагч сав	DL210	1	0.6	0.6
6	Фотометр	-	1	0.25	0.25
7	Анализатор	-	1	0.5	0.5
Нийт			8		9.77

Баяжуулалтын технологийн бэлэн бүтээгдэхүүн баяжмалын чанарт байнгын хяналт тавих дараах стандартуудыг үйл ажиллагаандаа мөрдөн ажиллана. Үүнд:

1. Лабораторийн шинжилгээний дээж авах ба түүнийг бэлтгэх. MNS 2205-83
2. Хайлуур жонш. Химийн шинжилгээний аргад тавих ерөнхий шаардлага. MNS 2699-86
3. Хайлуур жонш. Чийгийн агуулгыг тодорхойлох арга. MNS 2700-86
4. Хайлуур жонш. Гуравч ислийг тодорхойлох арга. MNS 2704-86
5. Хайлуур жонш. Хүхрийн нийт хэмжээг тодорхойлох арга. MNS 2706-86
6. Хайлуур жонш дахь нүүрсхүчлийн кальци болон фосфорт кальцийг тодорхойлох арга. MNS 4928-2000

Хүснэгт 7. Механик цехийн нийт тоног төхөөрөмж

№	Тоног төхөөрөмжийн нэр	Тоо	Нэгж чадал, кВт	Нийт чадал, кВт
1	Токарийн суурь машин	1	5.5	5.5
2	Цахилгаан гар дрель	1	1.5	3
3	Суурь машин	1	5.7	5.7
4	Гүүрэн кран	1	15	15
5	Суурийн точиль	1	2.8	5.6
6	Гагнуурын аппарат	1	4.5	4.5
Нийт		6		45.7

Зам тээвэр, харилцаа холбоо

Үйлдвэр нь Дундговь аймгийн Баянжаргалан сумаас 2.5 км зайд байрлах ба босоо тэнхлэгийн автозамаас 1.5 км зайд байрлана. Баяжуулах үйлдвэрээс 8 км зайд төмөр замын ачиж буулгах талбай байрлаж байгаа ба БҮ-ээс гарах жоншны баяжмалыг төмөр замын ачиж буулгах талбай хүртэл авто тээврээр тээвэрлэх ба, ачиж буулгах талбайгаас төмөр замын тээврээр урд хил


2026 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөө

хүртэл тээвэрлэнэ. Үйлдвэрээс өдөрт 39.2 тн баяжмал гарах ба 7 хоног 1 удаа буюу 276 тн баяжмал болмогц тээвэр хийхээр төлөвлөв. Гадаад тээврийг гэрээт компаниар хийлгэнэ.

Цахилгаан хангамж

Баяжуулах үйлдвэрийн хэрэглэгчид нь үйлдвэрийн ажлын горим, технологи, механикжуултал болон цахилгаанжуулалтын бүхий л онцлогуудыг тусгасан гадаад, дотоод цахилгаан хангамжтай байна.

Тус баяжуулах үйлдвэрийн цахилгаан хэрэглэгчдийг Дундговь аймгийн Баянжаргалан сумын төвд орших 35/10 кВ-ын дэд станцын 35 кВ-ын ил хуваарилах байгууламжаас 2.5 км урттай 10 кВ-ын өндөр хүчдэлийн цахилгаан дамжуулах шугамыг татаж БҮ-ийн дэргэд 10/0.4 кВ-ын трансформаторын бууруулах дэд станцыг барьж байгуулан үйлдвэрийн хэрэглэгчдийг цахилгаан эрчим хүчээр хангана.



Зураг 10. Үйлдвэрийн дотоод цахилгаан хангамжийн схем

Хүснэгт 8. ГЭНЭТИЙН АЮУЛ ОСЛЫН ҮЕД ЗОХИЦУУЛАХ ТӨРИЙН БАЙГУУЛЛАГУУД

№	Аюулт үзэгдэл ослын төрөл	Удирдан зохицуулах байгууллага	Говь аргатай ХХК өртөх боломжтой аюулууд
1	Газар хөдлөлт	ППП	+
2	Хүний гоц халдварт өвчин	ЭМСЯ	+

2026 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөө

3	Ган	ХХААЯ	+
4	Зуд	ХХААЯ	+
5	Хүчтэй цасан болон шороон шуурга	ОБЕГ	+
6	Үер	ОБЕГ	
7	Мал, амьтны гоц халдварт өвчин	ХХААЯ	+
8	Хортон шавьж, мэрэгчид тархах	БОНХАЖЯ	+
9	Ой хээрийн түймэр	ОБЕГ	+
10	Объектын гал түймэр	ОБЕГ	+
11	Химийн хорт болон аюулт бодис алдагдах	БОНХАЖЯ	
12	Цацраг идэвхт бодис алдагдах	МХЕГ	
13	Үйлдвэрлэлийн осол	ОБЕГ	+
14	Тээврийн хэрэгслийн осол	ЗТЯ	+
15	Хүнсний аюулгүй байдал алдагдах	ХАБҮЗ	+

Мөн дотооддоо аюул ослын үед хэрэгжүүлэх төлөвлөгөө тоног төхөөрөмжийн техникийн заалтыг боловсруулан мөрдлөг болгон ажиллана.

Эдийн засаг

2024 онд 40.0 мян.тн хүдэр баяжуулж нийт 8101.5 сая төгрөгийн борлуулалтын орлого олж, үүнээс 7584.1 сая төгрөгийн үйлдвэрлэл, үйл ажиллагааны зардал гаргаж 517.4 сая төгрөгийн татвар ногдох орлого олохоор төлөвлөсөн.

Бүлэг 2. Төсөл хэрэгжиж буй нутгийн байгаль орчин, нийгэм-эдийн засгийн төлөв байдлын товч танилцуулга

2.1. УУР АМЬСГАЛ ӨНӨӨГИЙН ТӨЛӨВ БАЙДАЛ

Дундговь аймгийн цаг уурын станцуудын ажиглагдсан мэдээнээс үзвэл сүүлийн 20 жилийн агаарын дундаж температур нь 3.0°С бөгөөд 1.4-4.7 хэмийн хооронд хэлбэлзэж байна. улирлаар авч үзвэл өвлийн дундаж температур нь -15.7 хэм бөгөөд -11.9-аас -19.1 хэмийн хооронд, зуны дундаж температур нь 20.0 хэм бөгөөд 18.4-21.9 хэмийн хооронд хэлбэлзэж байна. агаарын дундаж температур нь 2007 онд хамгийн дулаан, 2012 онд хамгийн хүйтэн байсан бол бусад жилүүд нь дундажтай ойролцоо байна. агаарын үнэмлэхүй хамгийн бага температур 2002 онд сайхан-овоо өртөөнд -41.0 хэм байсан бол үнэмлэхүй хамгийн их температур 2017 онд Баянжаргалан өртөөнд 41.0 хэм хүрчээ (badamsuren, 2022). хаврын улиралд 0 хэмээс дээш халах үе 3-р сарын сүүлийн арав хоногт тохиодог байна. хөлдөх температуртай өдрүүдийн эхлэх хугацаа нь 10-р сарын сүүлийн арав хоногт байдаг. олон жилийн дунджаар 0-ээс дээш хэмтэй хоногийн тоо 210 хоног, харин 0-ээс доош хэмтэй өдрийн тоо 156 хоног байна. зуны өдөр буюу хамгийн их температур 25 хэмээс дээш байх өдрийн тоо 4-р сараас эхэлж 10-р сар хүртэл үргэлжилдэг байна (*monthly aggregated climate dataset*, 2022).

агаарын жилийн дундаж температур 2.9-6.0 хэмийн хооронд хэлбэлзсэн байв. энэхүү хэлбэлзлийг задлан үзвэл 1999-2007 онд аажмаар нэмэгдэж, дээд тал нь 6.0 хэм хүрч, 2007-2012 онд аажмаар буурч хамгийн багадаа 2.9 хэм хүрсний дараа 2017 онд өссөн бөгөөд өгсөх буурах хандлага 1-3 жил тутамд өөрчлөгдсөн байна (badamsuren, 2022).

Дундговь аймагт дунджаар 120 мм хур тунадас унадаг байна. Сүүлийн 20 жилийн мэдээгээр Мандалговьд 84.6-188.0 мм, сайхан-овоод 25.7-222.2 мм, Эрдэнэдалайд 68.5-241.1 мм, Баянжаргаланд 46.5-195.1 мм хур тунадас оржээ (*monthly aggregated climate dataset*, 2022).

2.2. ГАЗРЫН ГАДАРГА, ХЭВЛИЙ ӨНӨӨГИЙН ТӨЛӨВ БАЙДАЛ

“Хайлуур жоншны хүдрийг гравитацын аргаар баяжуулах үйлдвэр байгуулах төсөл”- ийн нийт эзэмшил талбай нь 4.0 га байна. Өнөөгийн байдлаар төслийн эзэмшил талбайн газрын гадарга нь ямар нэгэн сөрөг нөлөөлөлд өртөөгүй байгалийн унаган төрхөөрөө байна.

2.3. ТӨСЛИЙН ТАЛБАЙН ГАДАРГЫН БОЛОН ГАЗРЫН ДООРХ УСНЫ ТӨЛӨВ БАЙДАЛ

Төслийн талбай нь ус зүйн хувьд дэлхийн ус хагалбарын Төв Азийн гадагш урсацгүй ай савд, Монгол орны Умард говийн гүвээт-Халхын дундад талын сав газарт тус тус багтана. Тухайн районд гадаргын усан сүлжээ хөгжөөгүй байна. Үйлдвэрийн эдэлбэр газрын орчимд гадаргын ил урсгалтай усгүй зөвхөн зуны улиралд түр зуурын тогтоол нуур болон хоолойг дагаж урсац үүсэх боловч тэдгээр нь үйлдвэрт үерийн нөлөөлөл үүсгэхгүй юм.

Төсөл хэрэгжих нутаг дэвсгэр нь гидрогеологийн мужлалын хувьд газрын доорх усны тэжээлийн горимоор улирлын хомс тэжээлтэй мужид хамааран, Дорноговийн гидрогеологийн дүүрэгт багтана. Төслийн талбайн ойролцоо нэг хуучин өрөмдмөл худгийн туурь, нэг малчны

гүний худаг байна. Байгаль орчны төлөв байдлын үнэлгээний ажлын хээрийн судалгааны хүрээнд төслийн талбайгаас баруун хойд зүгт 365 м зайд байрлах “Малчны гүний худаг”-ын уснаас дээж авч Газарзүй-Геоэкологийн хүрээлэнгийн Усны шинжилгээний лабораторид шинжлүүлэв.

2.4. ХӨРСӨН БҮРХЭВЧ ӨНӨӨГИЙН ТӨЛӨВ БАЙДАЛ

Цайвар хүрэн хөрс. Цөлөрхөг хээрийн бүсийн хойд хэсэгт үетэн-монгол өвст бүлгэмдэл голлож агь, сонгино, харгана нэлээн холилдсон газраар тархах бөгөөд ургамлын бүрхэц 20-30%-аас орчим байдаг. Хөрсний гадаргын ихэнх хэсэг ургамалгүй цулгуй байдаг учраас салхины үлэгдэлд хялбар өртөж том ширхэгтэй элс, жижиг сайр чулуугаар бүрхэгдсэн байдаг. Ялзмаг хуримтлалын давхарга (А) нь цайвар хүрэн өнгөтэй, бүдэг бөөмөрхөг бүтэцтэй, үе давхарга нэлээд тод илэрсэн, зузаан нь дунджаар 10 см байна. Түүний доорх арай нягтавттар шинжтэй, бага зэрэг ялзмагжсан, боровтор өнгөтэй В1 давхарга ихэнх тохиолдолд ялгарч харагдах бөгөөд давсны хүчилд бургих гүн янз бүр байна. Цайвар хүрэн хөрсний ялзмаг хуримтлалын давхарга дахь органик бодисын хэмжээ 1-2% орчим байх ба ялзмагийн найрлага дахь гуминийн хүчил, фульво хүчлийн хэмжээ ойролцоо ($C_{гх}:C_{фх}=0.9-1$) байна. Урвалын орчин хөрсний бүх үе давхаргад шүлтлэг шинжтэй, ялангуяа доод давхаргуудад илүү шүлтлэг байна. шингээх чадвар бага (100 гр хөрсөнд 9-15 мг/экв) солилцоот катионуудын найрлагад натри ион маш бага хувийг эзэлнэ. Өвөл 2.5-3 м хүртэл гүн хөлдөнө. Зуны хур борооны ус хөрсөнд дөнгөж 15-20 см гүн нэвчиж хөрсний профилийн дээд хэсгийг чийглэдэг. Үржил шимээр тааруухан, шим тэжээлийн бодисын хангамж бага байна. Хөрсний дээд 0-20 см үе дэх ялзмагийн нөөц 30-40 тн/га, бүх азотын нөөц 3 тн/га орчим байдаг. Энэ хөрс бэлчээрийн эдэлбэр газрыг бий болгох бөгөөд зөвхөн усалгаатай нөхцөлд тариаланд ашиглах боломжтой.

Хөрсний хими, физик шинж чанар:

“Говь-Аргатай девеломент” ХХК-ийн “Хайлуур жоншны хүдрийг гравитацын аргаар баяжуулах үйлдвэр байгуулах төсөл” хэрэгжих талбай орчимд тархсан хөрсний хими шинж чанар болон физик шинж чанарыг доорх хүснэгтүүдээр үзүүлэв.

Хөрс нь сул шүлтлэг урвалын (рН) орчинтой, зүсэлт BG-01-ийн 20-50 гүнд их ($CaCO_3$) карбонаттай, бусад дээж карбонатгүй болон бага карбонаттай, ялзмагийн агууламжаар бага, цахилгаан дамжуулах чанар бага буюу давсжилтгүй, хөдөлгөөнт фосфор (P_2O_5), болон калийн (K_2O) хангамжаар бага хангагдсан, хөрсний үржил шимийн ерөнхий түвшин бага байна.

Хөрсний бохирдолт: Байгаль орчны үнэлгээний ажлын хээрийн судалгааны үед төслийн талбайд хийсэн 2 зүсэлтийн өнгөн үе давхаргын хөрсний дээжийг сонгон авч итгэмжлэгдсэн лабораторид хүнд металл тодорхойлуулсан болно (Хүснэгт 29). Хөрсний дээжүүдэд 33 химийн элементийг тодорхойлсон боловч тэдгээрийн 12 элемент нь зөвшөөрөгдөх дээд хэмжээ нь MNS 5850:2019 стандартад нь тусгагдсан байдаг. Бусад 21 элементүүд нь одоогоор Монгол улсад мөрдөгдөх стандарт байхгүй байна. Тус хөрсний дээжүүдийн шинжилгээний үр дүнг “Хөрс бохирдуулагч бодис, элементүүд-MNS 5850:2019” стандарттай харьцуулан үзэхэд кобальт

(Co), хром (Cr), хар тугалга (Pb), цайр (Zn), стронций (Sr), ванадий (V), никель (Ni), молибден (Mo), кадмий (Cd), цагаан тугалга (Sn), зэс (Cu) зэрэг элементүүд нь хүлцэх агууламжаас даваагүй буюу эдгээр элементүүдийн бохирдолгүй байна. Харин BG-1-р дээжид хүнцэл (As) MNS5850:2019 стандартын зөвшөөрөгдөх дээд хэмжээнээс өндөр байна.

2.5. УРГАМЛАН БҮРХЭВЧ ӨНӨӨГИЙН ТӨЛӨВ БАЙДАЛ

Ургамалжлын бичиглэл: Төслийн талбайн хэмжээнд тархсан ургамлан нөмрөгийн үндсэн бүлгэмдэл нь Монгол өвс-харганат, Дэрс-нэг наст-таанат бүлгэмдэл байна. Тус талбай нь говийн цөлийн сөөглөг ургамалтай байх бөгөөд ургамлан нөмрөгийн 100 м² талбайд 6-16 зүйл, 1 м² талбайд 3-6 зүйл бүртгэж, ургамалжлын хувьд ургамлын бүрхэц 45-45.6%, га-ийн ургац 2.518-3.024 центнер байна.

1. Монгол өвс-харганат, Монгол өвс-харганат (146/ЦХ-I-1-5) бүлгэмдэлд (1-р цэг) Говийн хялгана (*Stipa gobica* Roshev.), Крыловын хялгана (*Stipa Krylovii* Roshev.), Алтан харгана (*Caragana leucophloea* Pojark.), Нарийн навчит харгана (*Caragana stenophylla* Pojark.) зонхилж, алаг өвснөөс Арзгар согсоот (*Heteropappus hispidus* (Thunbg.) Less.), Цөлийн тайр (*Gypsophila desertorum* (Bge.) Fenzl), Чөдөр сэдэргэнэ (*Convolvulus arvensis* L), буурцагтнаас Туулайн хунчир (*Astragalus laguroides* Pall.) бусад овгийн заримдаг сөөгөнцрөөс Дэлхээ тогторгоно (*Kochia prostrata* (L.) Schrad.), талхагдлын заагуур ургамлаас Гейманын бөөдий (*Aristida Heymannii* Rgl.), Бага хургалж (*Eragrostis minor* Host.), Умардын оготнын сүүл (*Enneapogon borealis* (Griseb.) Honda.), Сортой лууль (*Chenopodium aristatum* L.), Хянганы хамхуул (*Corispermum chinganicum* Iljin), Шүлхий шарилж (*Artemisia pectinata* Pall.), сонгинолог ба үндэслэг ишт ургамлаас Таана буюу баглагар сонгино (*Allium polyrrhizum* Turcz. ex RgL.), зэрэг нийт 100м² талбайд 7 овог, 14 төрөл, 16 зүйл ургамал ургасан, 1м² –д 4-6 орчим зүйл тааралдаж байв. Ургамлан нөмрөгийн тусгаг бүрхэц 42.0%, түүнээс талхагдлын заагуур ургамал 6.2%, нийт гадаргын бүрхцэд хайрга чулуу 9.4%, хагд 9.6%, халцгай газар 39% байна

2. Дэрс-нэг наст-таанат (223/ Н-III-3-4) (2-р цэг) бүлгэмдэлд үетнээс Гялгар дэрс (*Achnatherum splendens* (Trin.) Nevski), Мөлхөө хиаг (*Agropyron repens* (L.)P.B.), Шүлхий шарилж (*Artemisia pectinata* Pall.), Бага хургалж (*Eragrostis minor* Host.), Гейманын бөөдий (*Aristida Heymannii* Rgl.), Таана буюу баглагар сонгино (*Allium polyrrhizum* Turcz. ex RgL.) ургасан, нийт 3 овог, 6 төрөл, 6 зүйл ургамал ургасан, 1м² –д 3-5 зүйл тааралдаж байв. Ургамлан нөмрөгийн тусгаг бүрхэц 45.6%, түүнээс талхагдлын заагуур ургамал 4.8%, нийт гадаргын бүрхцэд хайрга чулуу 4.6%, хагд 19%, халцгай газар 30.8% байна

3. Монгол өвс-ерхөг-тэсэгт, Монгол өвс-харганат, Таана-монгол өвст (64-63-148/ У-VI-1-7; У-VI-1-6; ЦХ-I-1-7)

“Говь-Аргатай девелмент” ХХК-ийн хайлуур жоншны орд ашиглах төслийн талбай дахь ургамалжлын өнөөгийн төлөв байдал ба доройтол. Баяжуулах үйлдвэр байгуулах барилгын ажлын улмаас ургамлан нөмрөгт дараах гол сөрөг нөлөөллүүдийг үзүүлэхээр байна. Үүнд:

2026 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөө

- Баяжуулах үйлдвэрийг байгуулах барилгын газар шорооны ажлын үед 1.65 га талбайн хөрсөн бүрхэвч хүчтэй сөрөг нөлөөлөлд өртөж устахаар байна.
- -Барилгын ажлын улмаас төслийн талбайн ойр орчмын ургамлан нөмрөг талхлагдана.

Үйлдвэрийн үйл ажиллагааны үед ургамлан нөмрөгт дараах гол сөрөг нөлөөллүүдийг үзүүлэхээр байна. Үүнд:

- Үйлдвэрийн хашааны хаалганаас орон нутгийн шороон зам хүртэл 292 м урт, 14 өргөн шороон зам шинээр бий болохоор байна..
- Бүтээгдэхүүн тээвэрлэлтийн гадаад зам нь үйлдвэрийн талбайгаас Хөөт-Олон Овоот өртөө чиглэлийн нүүрс тээврийн зам хүртэлх 1.5 км энгийн шороон зам байна. Дээр дурдсан 292 м зам энд багтсан болно.
- Сайжруулсан шороон замд нийлж буй уулзвараас Олон-Овоот өртөө 83.8 км байна. Бүтээгдэхүүн тээврийн гадаад зам нь нийт 85.3 км болно.
- Бүтээгдэхүүн тээвэрлэлтийн үед дээрх шороон замуудаас дэгдэх тоосны тархалт нь хүрээлэн буй орчны ургамлан нөмрөгт гол сөрөг нөлөөллийг үзүүлнэ.
- Баяжуулах үйлдвэрийн үйл ажиллагааны нөлөөгөөр хөрс эвдэрч элэгдэн ургамлын бүтэц тодорхой хэмжээгээр өөрчлөгдөн, тоос шороонд дарагдах, үрэгдэх зэргээр талхлагдаж, ургац хомстоно;
- Тээвэрлэлтийн үйл ажиллагаанаас үүсэх тоосжилтод ойролцоох талбайн ургамлан нөмрөг өртөж ургамлын фотосинтезийн процесс удааширч багтрах, ургамлын гадарга, навч түлэгдэх сөрөг нөлөөтэй. Тээврийн хэрэгслийн хөдөлгөөний үед гарах тоосоор тодорхой талбайн ургамал дарагдана;
- Ургамлын төрөл зүйл хомсдох.
- Ахуйн болон үйлдвэрлэлийн гаралтай түр хогийн цэгийн стандартын дагуу байгуулаагүйн улмаас байгаль орчинд хог хаягдал салхиар тархах болон хөрсөнд нэвчих байдлаар ургамлан бүрхэвчийг бохирдуулна;

2.6. ТӨСЛИЙН ТАЛБАЙ ОРЧМЫН АМЬТНЫ АЙМАГ

Төслийн барилга байгууламжууд болон хамгаалалтын шороон далан, шуудуу байгуулах үйл ажиллагаа нь хөрс шүтэн амьдрагч мэрэгч амьтад, мөлхөгчид болон шавжийн зүйлийн бүрдэл, тоо толгойг бууруулах, амьдрах орчныг алдагдуулах сөрөг нөлөө үзүүлнэ. Төсөлд ашиглаж байгаа машин механизмаас гарч буй дуу чимээнээс болж томоохон хөхтөн амьтад төслийн талбай орчмоос дайжих, жижиг мэрэгч амьтад тээврийн хэрэгсэлд дайруулах тохиолдол гарна.

Төслийн ахуйн хаягдлыг ил байршуулсан тохиолдолд хэрээ, шаазгай, элээ зэрэг хаягдал шүтэн амьдардаг шувууд цуглаж болзошгүй. Төслийн үйл ажиллагааны улмаас тухайн орчны агаар, хөрс бохирдохын хирээр ургамлан нөмрөгт тодорхой хэмжээгээр өөрчлөлт гарах бөгөөд үүнтэй уялдан амьтны аймгийн амьдрах орчин доройтож, идэш тэжээл нь

хомсдож, тархац, газар нутгийн хэмжээ хумигдана.

2.7.Нийгэм, эдийн засаг өнөөгийн төлөв байдал:

Баянжаргалан сум нь 1925 онд байгуулагдсан байна. Сум анх байгуулагдахад 200 гаруй өрх, 1000 шахам хүн амтай, 40 орчим мянган толгой малтай, засаг захиргааны нэгж нь 5 багтайгаар зохион байгуулагдан сумын захиргаа үйл ажиллагаагаа эхэлж байжээ. Баянжаргалан сумын төв нь Улаанбаатар хотоос 300 км, аймгийн төвөөсөө 150 км-т, Монголын төмөр замаас 80 км зайтай оршдог. Баянжаргалан сум нь одоо 328.9 мян.км² газар нутагтай, засаг захиргааны хуваариар Аргатай (сумын төв), Шилийн гол, Энгэр-Ус гэсэн 3 багт хуваагдана. Тус сумын нутаг дэвсгэрт жонш, чулуун нүүрс, төмрийн хүдрийн уурхайнууд үйл ажиллагаа явуулдаг байна. “Говь-Аргатай девелопмент” ХХК-ийн “Хайлуур жоншны хүдрийг гравитацын аргаар баяжуулах үйлдвэр байгуулах төсөл”-ийн талбай нь 1-р багийн нутаг дэвсгэрт, сумын төвөөс зүүн урд зүгт 2.5 км зайд байрлаж байна. Баянжаргалан сумын нийт хүн ам нь 2019 оны жилийн эцсийн байдлаар 1261 байсан байна.

Бүлэг 3. Төслийн гол ба болзошгүй сөрөг нөлөөллийн товч тодорхойлолт

3.1 ТӨСЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС АГААРЫН ЧАНАРТ ҮЗҮҮЛЖ БОЛЗОШГҮЙ ГОЛ СӨРӨГ НӨЛӨӨЛӨЛ

“Хайлуур жоншны хүдрийг гравитацын аргаар баяжуулах үйлдвэр байгуулах төсөл”- ийн үйл ажиллагааны улмаас газрын гадаргад дараах гол сөрөг нөлөөллүүдийг үзүүлэхээр байна. Үүнд:

- Баяжуулах үйлдвэрийг байгуулах ажлын үед 1.65 га талбай хүчтэй сөрөг нөлөөлөлд өртөхөөр байна.
- Үйлдвэрийн хашааны хаалганаас орон нутгийн шороон зам хүртэл 292 м урт зам шинээр үүсэхээр байна. Баяжуулах үйлдвэрийн тээвэрлэлтээс үүдэлтэй сөрөг нөлөөлөл хамгийн ихээр бий болно.

3.2. ГАЗРЫН ГАДАРГА, ХЭВЛИЙ, ХӨРСӨН БҮРХЭВЧИД ҮЗҮҮЛЖ БОЛЗОШГҮЙ НӨЛӨӨЛӨЛ

Төслөөс газрын гадарга болон хэвлийд үзүүлж болзошгүй сөрөг нөлөөллийг дараах байдлаар тодорхойлов. Үүнд:

- Үйлдвэрийн хашааны хаалганаас орон нутгийн шороон зам хүртэл 292 м урт, 14өргөн шороон зам шинээр бий болохоор байна
- Бүтээгдэхүүн тээвэрлэлтийн гадаад зам нь үйлдвэрийн талбайгаас Хөөт-Олон Овоот өртөө чиглэлийн нүүрс тээврийн зам хүртэлх 1.5 км энгийн шороон зам байна. Дээр дурдсан 292 м зам энд багтсан болно. Тус 1.5 км шороон замыг Засгийн газрын 374-р тогтоолоор батлагдсан журмын хатуу хучилттай болгохыг зөвлөж байна.
- Сайжруулсан шороон замд нийлж буй уулзвараас Олон-Овоот өртөө 83.8 км байна. Бүтээгдэхүүн тээврийн гадаад зам нь нийт 85.3 км болно.
- Бүтээгдэхүүн тээвэрлэлтийн үед дээрх шороон замуудаас дэгдэх тоосны тархалт нь хүрээлэн буй орчны хөрсөн бүрхэвчид гол сөрөг нөлөөллийг үзүүлнэ.
- Баяжуулах үйлдвэрийг байгуулах барилгын газар шорооны ажлын үед 1.65 га талбайн хөрсөн бүрхэвч хүчтэй сөрөг нөлөөлөлд өртөж устахаар байна.
- Барилгын ажлын улмаас төслийн талбайн ойр орчмын ургамлын нөмрөг талхлагдана.

3.3. ГАДАРГЫН БОЛОН ГАЗРЫН ДООРХ УСАНД ҮЗҮҮЛЖ БОЛЗОШГҮЙ ГОЛ СӨРӨГ НӨЛӨӨЛӨЛ

Далд уурхайн малталтаас үүдэн тухайн нутгийн газрын доорх ус агуулагч бүрдэл хурдасны зүй тогтол өөрчлөгдөж болзошгүй;

- Баяжуулах үйлдвэрт ашиглаж буй гүний худгийн ашиглалтын нөөц, горимыг буруу тогтоосноос үүдэн худгийн ашиглалтын ундарга буурч болзошгүй;
- Баяжуулах үйлдвэрийн тээвэрлэлтийн үйл ажиллагаанаас үүдэн орон нутгийн гадаргын урсцын зүй тогтол алдагдаж, улмаар тухайн нутагт орших байнгын болон түр зуур ус тогтдог нуур, тойрмуудад сөргөөр нөлөөлж болзошгүй;

2026 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөө

- Баяжуулах үйлдвэрийн үйл ажиллагааны үед гарч Барилгын ажлын үед гарч буй хаягдал бохир ус болон, шатах, тослох материалын хаягдлаар ус бохирдож болзошгүй.

3.4. УРГАМЛАН БҮРХЭВЧИД, АМЬТНЫ АЙМАГТ ҮЗҮҮЛЖ БОЛЗОШГҮЙ ГОЛ СӨРӨГ НӨЛӨӨЛӨЛ

Төслийн барилга байгууламжууд болон хамгаалалтын шороон далан, шуудуу байгуулах үйл ажиллагаа нь хөрс шүтэн амьдрагч мэрэгч амьтад, мөлхөгчид болон шавжийн зүйлийн бүрдэл, тоо толгойг бууруулах, амьдрах орчныг алдагдуулах сөрөг нөлөө үзүүлнэ.

Төсөлд ашиглаж байгаа машин механизмаас гарч буй дуу чимээнээс болж томоохон хөхтөн амьтад төслийн талбай орчмоос дайжих, жижиг мэрэгч амьтад тээврийн хэрэгсэлд дайруулах тохиолдол гарна.

Төслийн ахуйн хаягдлыг ил байршуулсан тохиолдолд хэрээ, шаазгай, элээ зэрэг хаягдал шүтэн амьдардаг шувууд цуглаж болзошгүй. Төслийн үйл ажиллагааны улмаас тухайн орчны агаар, хөрс бохирдохын хирээр ургамлын нөмрөгт тодорхой хэмжээгээр өөрчлөлт гарах бөгөөд үүнтэй уялдан амьтны аймгийн амьдрах орчин доройтож, идэш тэжээл нь хомсдож, тархац, газар нутгийн хэмжээ хумигдана.

Хөрсний эвдрэл, доройтол, орчны тоосжилтын улмаас ургамал идэшт амьтдын тоо толгой буурахад нөлөөлнө. Төслийн үйл ажиллагаанаас шалтгаалан дуу чимээ, тоос гарах, усны нөөц багасах, бэлчээрийн доройтол болох зэрэг сөрөг үзүүлэлт гарснаар зэрлэг ан амьтад мөн сөрөг нөлөөлөл үзүүлнэ. Төслийн үйл ажиллагаанаас амьтны аймагт дараах сөрөг нөлөөллийг үзүүлнэ. Үүнд:

- Зарим төрлийн шавжийн амьдрах орчныг устгах;
- Төслийн үйл ажиллагаанаас гарах дуу чимээнээс амьтан, шувууд дайжих;
- Бүтээгдэхүүн тээвэрлэлтийн үйл ажиллагаа болон тээврийн замын нөлөөгөөр зарим амьтадын популяцын тусгаарлалт үүсэж, амьтадын нүүдэлд мэдэгдэхүйц сөрөг нөлөө үзүүлнэ;
- Шөнийн цагаар үйлдвэрлэлийн үйл ажиллагаа явагдсан нөхцөлд шөнийн амьдралтай амьтдад сөрөг нөлөөлөл учруулна. Дуу чимээ, гэрэл гарч, амьтад дайжих, махчин амьтад идэш тэжээлээ барих зэрэгт нөлөөлнө;
- Үйлдвэрийн цахилгаан хангамжийн агаарын шугам дээр шувууд сууснаар өндөр хүчдэлд цохиулан үхэж үрэгдэх сөрөг нөлөөлөл үүснэ.

3.5. НИЙГЭМ ЭДИЙН ЗАСАГТ ҮЗҮҮЛЖ БОЛЗОШГҮЙ НӨЛӨӨЛӨЛ

Төсөл хэрэгжих нутаг дэвсгэрийн иргэдийн нийгмийн байдал, эрүүл мэндэд үзүүлэх гол сөрөг нөлөөллийг дараах байдлаар тодорхойлов. Үүнд:

- Төслийн үйл ажиллагаа, тээвэрлэлтээс дэгдэх тоос нь орон нутгийн иргэдийн эрүүл мэндэд шууд сөрөг нөлөөлөл үзүүлнэ;

2026 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөө

- Төслийн аюулгүйн ажиллагааны дүрэм зөрчигдсөнөөс хүн амын эрүүл мэндэд сөргөөр нөлөөлөх, амь насанд аюул учрах зэрэг болно;
- Төслийн үйл ажиллагааны горим алдагдсанаас ажиллагсдын эрүүл мэндэд сөргөөр нөлөөлөх, амь насанд нь аюул учрах;
- Төслийн дотоод ба гадаад тээвэрлэлтийн буруу зохицуулалт, үйл ажиллагаанаас ослын төвшин нэмэгдэх;
- Үйлдвэрлэлийн ослын эрсдэл нэмэгдэнэ
- Төслийн хөдөлмөрийн аюулгүйн байдлаас болж хүмүүс бэртэх;
- Нутгийн иргэдийн малын бэлчээр төслийн үйл ажиллагааны сөрөг нөлөөнд өртөнө.

Бүлэг 4. Байгаль орчны менежментийн тухайн жилийн төлөвлөгөөний гол зорилт, хамрах хүрээ

Говь-Аргатай ХХК нь Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2019 оны 10 дүгээр сарын 29-ны өдрийн А/618 тоот тушаалаар шинэчлэн баталсан “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам”-ын дагуу Логийн хайлуур жоншны ордын 1 хүдрийн биетийн хойд хэсгийг далд аргаар ашиглах төслийн баяжуулах үйлдвэрийн 2026 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөг боловсрууллаа.

Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөө гэж Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн 9.8-д заасан төлөвлөгөөг ойлгоно. Ерөнхий үнэлгээ хийсэн байгууллагын хянаж баталсан тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөө нь төслийн үйл ажиллагааг эхлүүлэх, үргэлжлүүлэхийг зөвшөөрсөн байгаль орчны үндсэн баримт бичиг болно.

Говь-Аргатай ХХК ийн баяжуулах үйлдвэрийн 2026 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний байгаль хамгаалах төлөвлөгөөнд байгалийн нөөц баялгийг ашиглах явцад байгаль орчныг доройтохоос урьдчилан сэргийлэх, сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах, үлдэгдэл нөлөөллийг дүйцүүлэн хамгаалах, нөхөн сэргээх, нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох, түүх соёлын өвийг хамгаалахтай холбогдсон арга хэмжээг тодорхойлон, шаардагдах хөрөнгө зардлыг тооцож, хариуцах этгээд, хэрэгжүүлэх хугацаа, баримтлах хууль, журам, аргачлал, стандартыг тодорхойлж тусгалаа.

Говь-Аргатай ХХК -ийн баяжуулах үйлдвэрийн 2026 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний орчны хяналт шинжилгээний хөтөлбөрт байгаль орчны төлөв байдлын өөрчлөлт, сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, арилгах, бууруулах арга хэмжээ үр дүнтэй байгаа эсэх, сөрөг нөлөөллийн эрчим, цар хэмжээ нь зөвшөөрөгдөх хэмжээнд байгаа эсэхийг тогтоох ажиглалт, хэмжилт, дээжлэлт хийх байршил, давтамж, хариуцах этгээд, шинжилгээний арга, шаардагдах зардлыг тооцож орууллаа.

Говь-Аргатай ХХК 2026 оны байдлаар байгаль орчны менежментийн төлөвлөгөөг байгаль хамгаалах хууль тогтоомж, байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний үр дүн, батлагдсан байгаль орчны менежментийн төлөвлөгөө (5 жил)-нд үндэслэн боловсруулав. Мөн уурхайн тухайн жилийн БОМТ төлөвлөгөө тусдаа батлагдаж байгаа тул баяжуулах үйлдвэрт гол анхаарах химийн бодис эрсдэлийн үнэлгээнд зардлыг тусгав.

Бүлэг 5. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө

Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөнд техник хэрэгслээс агаарт тархах хорт утааг бууруулах, тоосжилтийг бууруулах зорилгоор замын усалгааг хийх, мониторингийн цэгүүдэд хяналт хийж дээжлэлт хэмжилт хийх ажлуудыг тусгаж өгсөн.

Үйлдвэрийн бүх төрлийн машин механизмд үзлэг оношилгоо засварыг тогтмол хийж, холбогдох стандартын шаардлагад нийцүүлэх зорилгоор хийлгэж байна. Үйлдвэрийн хогийн цэг, бие засах газруудад ариутгал халдваргүйжүүлэлт хийх ажлын хүрээнд сард бүр хийж гүйцэтгэнэ. Уурхайн тосгоны талбайд байгуулсан ногоон байгууламжийн арчилгаа тордлогоо усалгаа 6-8-р саруудад хийж гүйцэтгэнэ.. Ус хангамжийн гүний худагт усны тоолуурыг баталгаажуулна. Мөн Умард говь гүвээт халхын дундад хээрийн тойргийн сав газрын захиргаатай усны гэрээ байгуулан ажиллана. Нийт сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөнд 12735 000 төгрөг зарцуулахаар төлөвлөсөн.

2026 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөө

Хүснэгт 9. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал, төг	Тоо хэмжээ	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
5.1. Агаарын чанарт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө									
1	Төсөлд ашиглагдах машин механизм, дизель станцаас ялгаран гарах хорт хий орчны агаарыг бохирдуулах	Үйлдвэрийн бүх төрлийн машин механизмд үзлэг оношилгоо засварыг тогтмол хийж, холбогдох стандартын шаардлагад нийцүүлэх	Үйлдвэрт ашиглагдаж байгаа бүх машин техник	Ш	30 000	7	210 000	6-8 сард байршуулна	-Агаарын ба агаарын бохирдлын төлбөрийн тухай хууль, -MNS4585:2007 (Агаарын чанар, Техникийн ерөнхий шаардлага) -MNS3383:1982 (Агаар мандал, Бохирдлын эх үүсвэр, нөхцөл байдал ба тодорхойлолт) -MNS5885:2008 (Агаар бохирдуулагч бодисуудын хүлээн зөвшөөрөгдсөн концентрац,
2	Агаарын чанарт, тоосжилтыг хэмжих	Агаарын чанарт үзүүлэх нөлөөллийг тогтоох, бууруулахын тулд хяналт шинжилгээг тогтмол хэрэгжүүлнэ.	Үйлдвэрт талбай	Ш	ОХШ зардалд тусгасан.	тээвэрлэлтийн зам, орчим, кемп	-	10-р сард жилд 1 удаа	

2026 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөө

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал, төг	Тоо хэмжээ	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
									Техникийн ерөнхий шаардлага)
3	Тоосжилтийг бууруулах	Бутлуур шигшүүрийн хэсэгт тоосжилтийг тархахаас сэргийлсэн дээвэр, хаалт хийх	Баяжуулах үйлдвэр	Ширхэг		2	10 000 000	2026 оны 10 сард	Агаарын чанарын стандарт
4	Үйлдвэрийн ажилчдын байр орчимд бохирдол үүсэх	Үйлдвэрийн хогийн цэг, бие засах газруудад ариутгал халдваргүйжүүлэлт хийх	Хогийн цэг, бие засах газар	Ш	12000	12	144 000	Сард 1 удаа	
5	Том оврын техник хэрэгслээс тос, масло асгарч, хөрс усыг бохирдуулах	Үйлдвэрийн асгаралтын дотоод журам боловсруулж, дагаж мөрдөх	Тээвэрлэлтийн зам, баяжуулах үйлдвэр, засварын төв	1	-	-	300 000	9-12 сард	Байгаль орчныг хамгаалах тухай хууль Газрын тухай хууль Усны тухай хууль Газрын хэвлийн тухай хууль Химийн хортой ба аюултай бодисын тухай хууль

2026 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөө

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал, төг	Тоо хэмжээ	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
6	Усны хомсдол үүсэж болзошгүй	Ус хангамжийн гүний худагт усны тоолуурыг баталгаажуулах	Уурхайн ус хангамжийн гүний худаг	Ш	100 000		500 000	10 сард	MNS0900:2018-Ундны ус. Эрүүл ахуйн шаардлага, чанар, аюулгүй байдлын үнэлгээ
7	Усны хомсдол үүсэж болзошгүй	Усны газраар дүгнэлт гаргуулан, Сав газрын захиргаатай гэрээ байгуулан ажиллана.	Уурхайн ус хангамжийн гүний худаг	Ш	-	1	545.000	8 сард	MNS0900:2018-Ундны ус. Эрүүл ахуйн шаардлага, чанар, аюулгүй байдлын үнэлгээ
Нийт							12 735 000		

Бүлэг 6. Ногоон байгууламж, тэрбум модны хөтөлбөрийн ТӨЛӨВЛӨГӨӨ

“Говь-Аргатай девеломент” ХХК-ийн “Хайлуур жоншны хүдрийг гравитацын аргаар баяжуулах үйлдвэр байгуулах төсөл”-ийн талбай нь засаг захиргааны харьяаллын хувьд Дундговь аймгийн Баянжаргалан сумын 1-р багийн нутаг дэвсгэрт хамаарч байна. Төслийн талбай нь Баянжаргалан сумын төвөөс зүүн урд зүгт 2.5 км, Улаанбаатар хотоос зүүн урагш ойролцоогоор 300 км, Говь-сүмбэр аймгийн Чойр хотоос баруун урагш шулуунаар 80 км зайд байрлаж байна. Төсөл хэрэгжих талбайн хэмжээ нь 4.0 га болно. Иймээс техникийн болон биологийн нөхөн сэргээлт төлөвлөгдөхгүй.

Үйлдвэрийн орчны талбайн үзэмжийг сайжруулах, тоосжилтыг бууруулах, орчны агаарыг цэвэршүүлэх зорилгоор ногоон байгууламж байгуулсан.. Үйлдвэрийн талбайг тойруулан мод, бутны зурвас байгуулна. Зурвасын гадна талаас: 1-р эгнээнд хайлаас модыг 2-3 метрийн зайтай сөөлжүүлэн тарина. 2-р эгнээнд жигд, сухай зэргийн 3-4 настай 40-50 см өргөнтэй суулгацыг 30-50 см-ийн гүн шуудуунд 20-30 см-ийн зайтай тарьсан байгаа эдгээр модны арчилгаа тордолгоог хийж гүйцэтгэнэ.

Тэрбум мод арга хэмжээний хүрээнд жилд 500 мод соёлын төвд хэсэгт тарихаар төлөвлөсөн. Мөн өөрийн мод тарьдаг талбайг нэмэгдүүлэн жил бүр 200 мод тарихаар төлөвлөж байна.

ХҮСНЭГТ 10. ТЭРБУМ МОД ХӨТӨЛБӨРИЙН ХҮРЭЭНД ЗАРЦУУЛАХ АЖЛЫН 5 ЖИЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ ЗАРДАЛ

№	Хийгдэх ажлууд	Хугацаа, он	Нэгжийн зардал Мян.төг	Нийт зардал Мян.төг
1	Суманд 500 хайлаас мод тарих	2026	3.0	1500.0
	Нийт			1500.0

Бүлэг 7. Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах, тэрбум мод хөтөлбөрийн арга хэмжээний төлөвлөгөө

7.1. ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭ

Монгол улсын Шадар сайд, Байгаль орчин, аялал жуулчлалын сайд, Уул уурхайн хүнд үйлдвэрийн сайд, Хууль зүй, дотоод хэргийн сайд нарийн хамтарсан 167, А/698, А/336, А242 тушаалын дагуу нэгдсэн арга хэмжээг зохион байгуулах тухай Засгийн газрын 2020 - 2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт туссан уул уурхайн үйл ажиллагааны улмаас эвдэрч, олон жил орхигдсон 8000 га талбайг нөхөн сэргээх зорилтыг хангах, нөхөн сэргээлтийн ажлыг эрчимжүүлэх ажлын хүрээнд Дундговь аймгийн Баянжаргалан сумын нутагт үйл ажиллагаанд өртөж орхигдсон 5768 м² талбайд Дундговь аймгийн Баянжаргалан сумын засаг даргын 2024 оны 02-р сарын 26-ны өдрийн 65 тоот албан бичгээр ирүүлсэн саналыг дагуу сонгосон. 2026 онд энэхүү талбайн нөхөн сэргээлтийг бүрэн гүйцэтгэнэ.

ГОВЬ-АРГА ТАЙ ХХК-ИЙН БАЯЖУУЛАХ ҮЙЛДВЭРИЙН ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ НӨХӨН СЭРГЭЭЛТ ХИЙХ ТАЛБАЙН СУРАГ



Өмнөх жилийн үлдэгдэл нөхөн сэргээлтийн талбайн энэ жил гүйцээн нөхөн сэргээхээр төлөвлөсөн.

2026 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөө

Хүснэгт 11. Д дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө, зардал

№	Хийгдэх он	Хийгдэх ажлууд	Нэгжийн зардал мян.төг	Нийт зардал Мян.төг	Тайлбар
1	2026	Сүүл өндөрт техникийн нөхөн сэргээлт хийх		2829.0	Өмнөх жилээс үлдсэн нөхөн сэргээлтийг хийх



ДУНДГОВЬ АЙМГИЙН БАЯНЖАРГАЛАН
СУМЫН ЗАСАГ ДАРГА
Дөш 4-411, 3-р баг, Баянжаргалан сум, Дундговь аймаг
48020
Утас: 75079911, Факс: (976) 75079911
Цахим шуудан: info@bayanjargalan.du.gov.mn
Цахим хуудас: www.bayanjargalan.du.gov.mn

2026.02.10 № 01/96
танай -ны № -т

ДУНДГОВЬ АЙМГИЙН БАЙГАЛЬ
ОРЧНЫ ГАЗАРТ

Тус сумын 3 дугаар багт ГОВЬ-АРГАТАЙ ДЕВЕЛОПМЕНТ ХХК жонш баяжуулах үйлдвэрийн үйл ажиллагаа эрхэлдэг бөгөөд 2025 оны байгаль орчны менежментийн дүйцүүлэн хамгаалах төлөвлөгөөний дагуу сумын төвд 100ш хайлаас тарьсан, ургалтын хувь нь 85,5%-тай мөн 3 дугаар багийн нутаг сүүл өндөр нэртэй 1200.150м.куб эвдэрсэн газарт 7,963.800 төгрөгийг зарцуулж дүүргэлт хийсэн.

2026 онд тус газрын нөхөн сэргээлтийг бүрэн дуусгаж орон нутагт хүлээлгэн өгөх нь үнэн болно.



Дундговь аймгийн Баянжаргалан сумын
засаг даргын тамгын газар
Удирдлага
Засаг дарга
Оюун Ууганбаатар
2026-02-10 15:03:19



2026 онд 2829 000 төгрөг Сүүл өндөр талбайд зарцуулахаар төлөвлөсөн.

Бүлэг 8. Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөө

Тухайн төслийн үйлдвэрлэлийн болон эрчимтэй сөрөг нөлөөллийн бүсэд иргэд, оршин суугчид, айл өрх, байгууллага байхгүй байна. Иймд нүүлгэн шилжүүлэх төлөвлөгөө тусгагдаагүй болно.

Бүлэг 9. Түүх соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө

Тусгай зөвшөөрлийн талбайд түүх соёлын дурсгалт зүйлс байхгүй хэдий ч илэрсэн тохиолдолд арга хэмжээ авахаар 300000 төгрөгийг төлөвлөв.

2026 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөө

Бүлэг 10. Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө

Үйлдвэрийн байгаль орчинд үзүүлэх нөлөөллийг бууруулах гол арга зам бол осол, эрсдэлийг гаргахгүй байх юм. Иймээс баяжуулах үйлдвэрийн 2026 онд аюулын үед авч хэрэгжүүлэх төлөвлөгөөг боловсруулж батлуулахаар төлөвлөсөн. Үйлдвэрийн аюулгүй ажиллагааны хүрээнд кемп үйлдвэрийн байранд галын иж бүрэн хорыг байршуулахаар төлөвлөсөн. Эдгээр ажлын зардалд 1500 000 төгрөг зарцуулах бөгөөд ажилчдын хөдөлмөр хамгааллын хэрэгслээр хангах зардлыг үйл ажиллагааны зардалд тусгахаар төлөвлөсөн.

Хүснэгт 12. Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө

№	Болзошгүй аюул, осол, сөрөг нөлөөлөл	Урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар хэмжээ	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, төг	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	2026 оны аюулын үед хэрэгжүүлэх төлөвлөгөө боловсруулах	Аюулын үед авч хэрэгжүүлэх төлөвлөгөө боловсруулах	Үйлдвэрийн объект хамаарна.	1	2000 000 төг		2026 онд 9сард	ОБЕГ-ын даргын 2016 оны 3 дугаар сарын 25-ны өдрийн А/75 дугаар тушаалын хоёрдугаар хавсралт
2	Ажилчид гэмтэж бэртэх	Ажилчдыг хөдөлмөр хамгаалалтын хэрэгслээр хангаж ажиллах	Бүх ажилчид		Үйл ажиллагааны зардалд орно.			
3	Гал түймэр гарах	Төслийн талбайд галын хор байршуулах	Кемп, үйлдвэр, засварын цэгт	2 ш	250 000	500 000	10 сард	
4	Ажилчдын хайхрамжгүй үйлдлээс болж осол гарах	Ажилчдад хөдөлмөр хамгаалал аюулгүй ажиллагааны сургалт явуулах	Бүх ажилчид	Өдөр бүр	ХААБ мэргэжилтэн		10 сард	
Нийт					2500 000			

Бүлэг 11. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө

11.1. Хог хаягдлыг бууруулах, дахин ашиглах, боловсруулах

Хог хаягдлын менежментийг амжилттай хэрэгжүүлэхийн үндэс нь ангилан ялгалт юм. Ангилан ялгаж байгаагийн давуу тал нь дахин ялгах шаардлагагүйгээр шууд дахин боловсруулах үйлдвэрт тушаах боломжтой болж байгаа явдал юм. Ангилан ялгахын тулд хог хаягдал гарах эх үүсвэр цэг бүрд тохирох төрлийн хогийн савнуудыг байрлуулав.

Үйлдвэрийн ажилчдын хотхонд ахуйн гаралтай хог хаягдлыг ангилан түр хадгалах хогийн саванд цуглуулна. Ахуйн болон хатуу хог хаягдлыг ангилсны дараа дахин ашиглах хатуу хог хаягдлыг тээвэрлэн хоёрдогч түүхий эд авдаг төвлөрсөн цэгт тушаахаар түр хадгалж байна. Техникийн ашигласан тос масло битүүмжлэл сайтай саванд цуглуулан дахин боловсруулах үйлдвэрт тушаана. Бусад хатуу хог хаягдлыг ялган, зориулалтын саванд цуглуулан, тусгайлан тээврийн хэрэгслээр зөөж тогтоосон цэгт хаяна.



ЗУРАГ 11. ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ЗАРЧИМ

Төслийн талбайд үйлдвэрлэлийн бүхий л үе шатнаас гарах хог хаягдлыг хүрээлэн буй орчин, хүний эрүүл мэндэд сөрөг нөлөөлөл үзүүлэхгүй байх талаас анхаарч урьдчилан сэргийлэх, хязгаарлах, хамгаалах, дахин ашиглах арга хэмжээг төлөвлөж удирдлага зохион байгуулалтаар хангаж зохицуулан ажиллах нь чухал байдаг. Ингэснээр хог хаягдал үүсгэгч этгээд /ажилтан, албан хаагч, хэлтэс нэгж/-ийн хог хаягдлын зохистой хэрэглээг хэвшүүлснээр хүрээлэн буй орчны бохирдлоос сэргийлэх, төслийн үйл ажиллагааны уялдаа холбоонд эерэг үр дүнтэй.

11.2. Хог хаягдлын тооцоо, судалгаа

Энгийн болон ахуйн хог хаягдал

Энгийн хог хаягдлын дийлэнх хувийг ахуйн хог хаягдал бүрдүүлнэ. Ажилчдын өдөр тутмын хэрэглээнээс гарах ахуйн гаралтай хог хаягдлууд болох хоол хүнсний үлдэгдэл, материалын сав баглаа боодол цаас, пластмасс, төмөр, шил, яс, мод зэрэг хог хаягдлууд байна. Төслийн талбайд хог хаягдлын төрөлд тохирсон түр хадгалах цэгүүд байдаг. Эдгээр цэгүүдэд хаягдал хуримтлагдсан үед зохицуулах зохих арга хэмжээг стандартын дагуу авч ажилладаг. Энгийн хог хаягдлын хувьд түр цэгт хуримтлуулан Дорноговь аймгийн Даланжаргалан сумын нэгдсэн хогийн цэгт хүргэнэ. Дахин ашиглах хог хаягдлыг түр цэгт хуримтлуулан уурхайн дотоод хэрэгцээндээ ашигладаг. Дахин боловсруулах хог хаягдлыг түр цэгт хуримтлуулан гэрээт байгууллагууд руу хүргэх, гэрээт байгууллагуудаас зориулалтын машин уурхайд ирж авах зэргээр ажиллаж байна. Ажилчдын хэрэгцээнээс хоол хүнсний үлдэгдэл, усны сав, элэгдэж хуучирсан аяга, таваг, уут баглаа боодол, хуванцар, шил, цаас зэрэг ахуйн гаралтай хаягдлууд үүсдэг. Нэг хүн хоногт 0.5 кг, жилд дунджаар 200 кг хог хаягдал гаргадаг гэсэн судалгаагаар нийт 33 ажилчдаас тооцоход:

- Хоногт 16.5 кг

- Сард 495 кг

- Жилд 5,280 кг

Үйлдвэрлэлийн хог хаягдал

Технологийн хаягдлын цэгт үүссэн хаягдлыг ангилан ялгаж хадгалах ба дахин боловсруулах тусгай зөвшөөрөл бүхий гэрээт үйлдвэр, байгууллагуудад нийлүүлэх, мөн уурхайн дотоод хэрэгцээнд дахин ашиглах үйл ажиллагаа явуулдаг.

Хүснэгт 13. Төслийн үйл ажиллагаанаас гарах хатуу хог хаягдал сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх зорилгоор хог хаягдлыг ангилан ялгана.

Хаягдал	Ангилал	Эх үүсвэр	Зохицуулалт	Тээвэрлэлт ,устгал
Цаасан хайрцаг	Энгийн	Хүнсний бүтээгдэхүүний сав баглаа боодол	Хогийн түр хадгалах	Дахин ашиглах
Хүнсний хаягдал	Энгийн	Хоолны үлдэгдлээс	Хогийн түр хадгалах цэгт хадгална	Даланжаргалан сумын төвлөрсөн хогийн цэгт хүргэнэ
Хуванцар сав	Энгийн	Ундны усны хэрэглээнээс	Хогийн түр хадгалах цэгт хадгална.	Дахин боловсруулан үйлдвэрт хүргэнэ.
Хаягдал төмөр	Энгийн	Засвар үйлчилгээнээс	Хогийн түр хадгалах цэгт хадгална.	Гэрээт байгууллагад өгнө

2026 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөө

Ахуйн шингэн хаягдал	Энгийн	Угаалга цэвэрлэгээ, шүршүүр, ариун цэврийн газар	Саарал ус цэвэршүүлэх төхөөрөмж авч суурилуулах	Дахин ашиглах
Ашигласан хүнсний сод	Энгийн	Хоол үйлчилгээ	Тодорхой хугацаанд хуримтлуулж хадгална.	Гэрээт байгууллагад өгнө
Ашигласан дугуй	Энгийн	Засвар үйлчилгээнээс	Дахин ашиглах	Байгалийн аясаар дэгдсэний дараа хаягдал чулуулгийн овоолго талбайд байршуулна.

Төслийн ахуйн хог хаягдлын эх үүсвэр бүрд хаягдлыг ангилан ялгаж хаях зориулалтын хогийн сав байрлуулах. Ангилсан хог хаягдлыг сумын төвлөрсөн хогийн цэгт хаях. Хог хаягдлыг кодчилсон жагсаалтын дагуу тухай бүрд нь хөтөлж, бүртгэх. Үйлдвэрийн талбайд үйл ажиллагааны турш хаягдал дугуйг өөрсдийн хэрэгцээнд дахин ашиглах, шаардлагатай бол орон нутгийн хэрэгцээнд өгөх, хэрэглэсэн шатах тослох материалыг УБ хотын Багахангай дүүрэгт “Ахуй мандал” хаягдал тос боловсруулах үйлдвэрт тушаана. Үйлдвэрийн хаягдал дугуйг өөрсдийн хэрэгцээнд дахин ашиглах, шаардлагатай бол орон нутгийн хэрэгцээнд өгөх хэрэглэсэн шатах тослох материалыг УБ хотын Багахангай дүүрэгт “Ахуй мандал” хаягдал тос боловсруулах үйлдвэрт жилд 2 удаа тушааж хог хаягдлын тухай хуулийг дагаж мөрдөх мөн хаягдал тос боловсруулах үйлдвэрт тушаана. Энэхүү ажлын зардалд 7108 000 төгрөг зарцуулахаар төлөвлөсөн.

2026 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөө

Хүснэгт 14. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө

№	Хог хаягдлын ангилал	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал, төг	Тоо хэмжээ	Нийт зардал, төг Хэрэгжүүлэх хугацаа	Хэрэгжүүлэх хугацаа	Баримтлах эрх зүйн баримт бичиг
	Ахуйн	Хог хаягдлын эх үүсвэр бүрд хог хаягдлыг ангилан ялгаж хаях зориулалтын хогийн сав байрлуулах. Ангилсан хог хаягдлыг сумын төвлөрсөн хогийн цэгт хаях.	Үйлдвэрийн талбайд	л	40 000	5.2	208 000	9-11 сард	Хаягдал дугуйг өөрсдийн хэрэгцээнд дахин ашиглах, шаардлагатай бол орон нутгийн хэрэгцээнд өгөх Хэрэглэсэн шатах тослох материалыг УБ хотын Багахангай дүүрэгт “Ахуй мандал” хаягдал тос боловсруулах үйлдвэрт тушаах
		Хог хаягдлыг кодчилсон жагсаалтын дагуу тухай бүрд нь хөтөлж, бүртгэх.	Үйлдвэрийн талбайд	х	х	х	100 000	9-11 сард	Хог хаягдлын тухай хууль. БОАЖС-ын 2018 оны А/428 дугаар тушаал
	Үйлдвэрийн	Хаягдал дугуйг өөрсдийн хэрэгцээнд дахин ашиглах, шаардлагатай бол орон нутгийн хэрэгцээнд өгөх	Үйлдвэрийн талбайд	х	х	х	500 000	9-11 сард	Хог хаягдлын тухай хууль

2026 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөө

№	Хог хаягдлын ангилал	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал, төг	Тоо хэмжээ	Нийт зардал, төг Хэрэгжүүлэх хугацаа	Хэрэгжүүлэх хугацаа	Баримтлах эрх зүйн баримт бичиг
		Ашигласан тос маслог цуглуулах	Үйлдвэрийн талбайд	Л	1000	800	800 000		хаягдал тос боловсруулах үйлдвэрт тушаах БОАЖС-ын 2018 оны А/428 дугаар тушаал
	Аюултай хог хаягдлын цэгийг сайжруулж	Аюултай хог хаягдал аюулгүй хадгалах	Үйлдвэрийн талбайд	5*6			5000 000	10 сард	Хог хаягдлын тухай хууль
	Аюултай	Хаягдал аккумулятор, тосны шүүр цуглуулах	Үйлдвэрийн талбайд	Кг	1000	500	500 000	9-11 сард	Хог хаягдлын тухай хууль. БОАЖС-ын 2018 оны А/428 дугаар тушаал
	Нийт						7108 000		

Бүлэг 12. Химийн бодисын эрсдэлийн менежментийн төлөвлөгөө

“Жонш баяжуулах үйлдвэр байгуулах төсөл”-ийн технологийн үйл ажиллагаанд химийн бодис ашиглахгүй

Бүлэг 13. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр

Орчны хяналт-шинжилгээний хөтөлбөрийг бүрэн хэрэгжүүлэх, батлагдсан арга, аргачлалаар дээжлэлт, хэмжилт хийх, холбогдох нарийвчлал, тохиргоог хангасан багаж тоног төхөөрөмжөөр шинжилгээг хийлгэх, үр дүнг шаардагдах нэгжийн системээр гаргах зэрэг бүхий л үйл ажиллагааг Говь-Аргатай ХХК хариуцах болно. Байгаль орчны хяналт шинжилгээг тус компанийн байгаль орчны мэргэжилтэн хариуцан гүйцэтгэх эсвэл мэргэжлийн байгууллагатай хамтран ажиллана. "Говь-Аргатай ХХК хайлуур жоншны баяжуулах үйлдвэр нь үйл ажиллагааныхаа явцад байгаль орчинд учруулж буй нөлөөлөл, түүний хэмжээ, цар хүрээ, байгаль орчны бүрэлдэхүүн хэсгүүдэд гарч буй өөрчлөлтийг хянаж, байгаль орчныг хамгаалах ажлын үр дүнд тулгуурлан цаашид авах арга хэмжээг нарийвчлан төлөвлөх зорилгоор орчны хяналт, шинжилгээний хөтөлбөрт тусгасан арга хэмжээг бүрэн хэрэгжүүлэх шаардлагатай. Орчны хяналт-шинжилгээний хөтөлбөрийн үр дүнд байгаль орчны төлөв байдалд өөрчлөлт орох, бохирдлын хэмжээ байгаль орчны стандарт, нормоос хэтэрч илрэх тохиолдолд мэргэжлийн байгууллагад яаралтай хандаж, холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлнэ. Агаарын чанарт 2 цэгт, хөрсөн бүрхэвч 2, эргэлтийн усан сангийн 1 цэгт тус бүр хэмжилт дээжлэлтийг хийхээр төлөвлөсөн. Нийт зардалд 5170 600 төгрөг зарцуулахаар төлөвлөсөн.

2026 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөө

Хүснэгт 15. 2026 онд хэрэгжүүлэх орчны хяналт шинжилгээний хөтөлбөр

Бүрэлд	Хяналт шинжилгээ хийх үзүүлэлтүүд	Байршил	Хугацаа ба давтамж	Нэгжийн өртөг, мян.төг	Нийт зардал мян.төг/жил	Баримтлах стандарт ба арга аргачлал
Агаарын чанар	Нийт тоосжилт, нүүрстөрөгчийн исэл, хүхэрт устөрөгч, азотын давхар исэл	Баяжуулах үйлдвэр Ажилчдын байр Тээврийн зам дагуу	10 сард	20 минутын хэмжилт хийж (SO ₂ , NO ₂ , тоос)-ийг хамт тооцоход 47.0 мян.төг	500 000	– MNS3113:1981. Агаар мандлын бохирдлыг хэмжих аргачлалын ерөнхий шаардлага – MNS0017-2-3-16:1988. Агаар мандал-Хот, суурин газрын агаарын бохирдлын шинжилгээ – MNS3384:1982. Агаар мандал-Агаарын дээжилж шинжилгээ
Хөрсөн бүрхэвч	Ерөнхий хими шинжилгээ Хөрсний хүнд металлын шинжилгээ Эрүүл ахуйн шинжилгээ	Баяжуулах үйлдвэр орчимд Ажилчдын байр Нүхэн жорлон	10 сард	$20*2=40.0$ $45*3=135.0$ $50*1=50$	615 000	– MNS3985-87 Хөрсний ариун цэврийн байдлын үзүүлэлтийн нэр, төрөл – MNS3310-91 Хөрсний агрохимийн үзүүлэлтийг тодорхойлох – MNS2305-94 Дээж авах, савлах, тээвэрлэх, хадгалах журам – MNS(ISO)4814:1999. Атом Шингээлтийн Спектрометрээр шинжилгээ хийх

2026 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөө

Бүрэлд	Хяналт шинжилгээ хийх үзүүлэлтүүд	Байршил	Хугацаа ба давтамж	Нэгжийн өртөг, мян.төг	Нийт зардал мян.төг/жил	Баримтлах стандарт ба арга
Усан орчин	Усны ерөнхий химийн шинжилгээ	Усан хангамжийн гүний 2 худгаас	10 сард.	46 ¹ *1=46.0	173.8	– MNS0900:2005 Ундны ус-Ундны усны хяналт шинжилгээ – MNS3935:1986 Ундны ус-Усны шинжилгээнд тавигдах шаардлага – MNS3936:1986 Ундны ус болон үйлдвэрийн ус-Тухайн талбарт нь шинжилгээ хийх – MNS4432:1997 Ундны ус-Хуурай үлдэгдлийн хэмжээг тодорхойлох – MNS3934:1986 Ундны болон үйлдвэрийн ус-Химийн шинжилгээ хийх-дээж авах, хадгалах, зөөвөрлөх – MNS5667-10:2001 Усны чанар-Дээж авах-2-р бүлэг. Хаягдал уснаас дээж авах – MNS5667-2:2001 Усны чанар-Дээж авах-2-р бүлэг Дээж авах арга – MNS4867:1999 Усны чанар-Дээж авах-3-р бүлэг Авсан дээжийг зөөвөрлөх, хадгалах арга
	Усны эрүүл ахуйн шинжилгээ			49.7 ² *1=49.8		
	Усны хүнд металлын шинжилгээ	Эргэлтийн усан сан		78 ³ *1=78.0		
	Нийт			1288.800		

¹ Газарзүй гео-экологийн хүрээлэнгийн усны лаборатори

² Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлагийн Хяналтын төв лаборатори

³ Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлагийн Хяналтын төв лаборатори

Зураг 12. Орчны хяналт шинжилгээ авах цэгийн байршил



Бүлэг 14. Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө

Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөөнд 10-р саруудад хийсэн орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн хүрээнд хийгдсэн хэмжилт дээжлэлтийн үр дүнг Баянжаргалан сумын иргэд танилцуулах санал зөвлөгөөг сонгох зорилгоор 10-р сард уулзалт зохион байгуулахаар төлөвлөсөн. Баянжаргалан сумтай хог хаягдлын гэрээ байгуулж ажиллана. Энэхүү ажлын нийт зардал 3000 000 төгрөг байна.

Хүснэгт 16. Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө

№	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Хугацаа	Зардал, төг	Хариуцагч
1.	Байгаль орчны удирдлага зохион байгуулалтын арга хэлбэрийг үйл ажиллагаандаа хэрэгжүүлэх чиглэлээр үүрэг хариуцлагын дотоод журам тогтоож мөрдөнө	9-11 сард	Дотоод төлөвлөлтөөр	Уурхайн дарга
2.	Хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны хувцас хэрэгсэл болон болзошгүй галын ажилгүй ажиллагааны багаж хэрэгслээр хангана.	9-11 сард	Үйл ажиллагааны зардалд орсон	Компанийн захирал
3	Сургуулийн хүүхдийн ор дэр цагаан хэрэгслийг шинэчлэх ажлыг хийнэ.	10 сард	3000 000	Компанийн захирал
4	Орон нутгийн иргэдийг ажлын байранд хангах	9-11 сард		
Дүн			3000 000	

Бүлэг 15. Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг нөлөөлөлд өртөгч оршин суугчид, оролцогч талуудад тайлагнах хуваарь

Нийт хийгдсэн ажлуудыг нэгтгэн дүгнэж өмнө 10-р сарын уулзалтаар өгсөн саналыг хэрэгжүүлж эхэлсэн талаар Баянжаргалан сумын иргэд, Дундговь аймгийн Байгаль орчны газар, танилцуулга хийхээр төлөвлөсөн. Мөн тухайн жилийн биелэлтийн тайланг 2026 оны 11-р сарын 1-ны өдөр аймгийн байгаль орчны газар болон Баянжаргалан сумын ЗДТГ-т хүргэн өгөхөөр төлөвлөсөн.

Хүснэгт 17. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг тайлагнах хуваарь, зардлын задаргаа

Хугацаа	Нөлөөлөлд өртөгч оршин суугчдад танилцуулах ажил	Зардал	Зохион байгуулах хүний албан тушаал
2026.10	үйл ажиллагаатай сум орон нутгийн иргэд, ЗДТГ-ын мэргэжилтэн, танилцуулах	250 000	Уурхайн дарга болон компанийн захирал
2026.10	Уурхайн үйл ажиллагаа, байгаль орчны менежментийн төлөвлөгөөний дагуу хийгдэж буй ажил, нөхөн сэргээлтийн явц зэргийн орон нутгийн иргэдийн төлөөлөлд танилцуулж, бусад сонирхсон асуудлаар чөлөөт ярилцлага хийнэ.	250 000	Уурхайн дарга болон компанийн захирал
2026.11	Байгаль хамгаалах талаар хийсэн ажлын жил бүрийн тайланг БОУАӨЯ, аймгийн байгаль орчны газар болон Баянжаргалан сумын ЗДТГ-т хүргэн өгч байна.	дотоод төлөвлөлтөөр	Компанийн захирал, уурхайн дарга
	Нийт	500 000 төг	

Байгаль орчны менежментийн 2026 оны төлөвлөгөөний нэгдсэн төсөв, дүгнэлт

Говь аргатай девеломент” ХХК-ийн хайлуур жоншны хүдрийг гравитацын аргаар баяжуулах үйлдвэр нь Дундговь аймгийн Баянжаргалан сумын нутаг дэвсгэрт орших ба Баянжаргалан сумын төвөөс зүүн урагш 2.5 км, Мандалговь хотоос зүүн тийш 153 км, Улаанбаатар хотоос зүүн урагш 315 км зайтай төмөр замын дагуу дэд бүтэц сайн хөгжсөн (цахилгаан эрчим хүч, төмөр зам, авто зам, газрын гүний усны нөөц) бүс нутагт 4.0 га талбайг хамран оршино.

Хайлуур жоншны хүдрийг гравитацын аргаар баяжуулах ТЭЗҮ-ийг 2020 оны 6-р сард ЭБМЗ-өөр хэлэлцүүлэн батлуулж 2024 оноос үйл ажиллагаа эхлүүлэхээр төлөвлөж байна. 2020-2021 онд төслийн талбайд усан хангамжийг бүрэн шийдсэн ба 2 цэгт худаг өрөмдөж паспорт аваад байна. 2023 онд үйлдвэрийн барилга угсралт, тоног төхөөрөмжийн угсралт суурилуулалтыг ажлыг гүйцэтгэж, үйлдвэрийг асаан жигдрүүлж ажиллуулахад бэлэн болсон.

Баяжуулах үйлдвэр нь 2025 онд “Тайшаншин юань” ХХК-ийн Дорноговь аймгийн Айраг сумын нутагт орших хайлуур жоншны MV-012412 тоот ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй ордоос 30-35%-ийн агуулгатай 40.0 мян.тн хүдэр худалдан авахаар төлөвлөсөн.

“Говь аргатай девеломент” ХХК-ийн захиалгын дагуу “Хүрд-Ус” ХХК нь 2019 онд 1980-аад онд бэлчээрийн талбайн ус хангамжид зориулан өрөмдсөн өрөмдмөл худгийг засварлах ажлыг хийсэн. Уг худагт их засварын ажил хийж ашиглалтад бэлтгээд цахилгаан насосоор шавхалт хийж үзэхэд ундарга 2.5 л/сек байна. Усны нөөцийн судалгааны хайгуулын өрөмдлөгийн ажил хийгдэж 3 цэгт өрөмдөж усны нөөцийг урьдчилан байдлаар хийн шавхалтын ажил хийгдсэн.

Баянжаргалан сумын 3 багийн Говь-Аргатай девеломент ХХК үйлдвэрийн талбайд өрөмдсөн гидрогеологийн хайгуул судалгааны өрөмдлөгийн ажлын журналаас харахад делюви, пролювийн сэвсгэр хурдас 20 м орчим түүнээс доош гүний чулуулаг тархсан байна. Сэвсгэр хурдас нь бор өнгийн шороо хайр, дайрга зэргээс бүрдэх ба ул чулуулаг нь брекчи, андезит, хар өнгийн занар зэргээс тогтоно. Гидрогеологийн энгийн нөхцөлтэй усны химийн найрлагын хувьд эрдэсжилт өндөртэй 1-3 г/л ус нь химийн найрлагаараа гидрокарбонат, кальци, магни зонхилсон байна.

Эргэлтийн усны хангамж нь технологийн ус, тоос дарах болон бусад шаардлагатай усны хэрэглээг хангах бөгөөд эргэлтийн усны сан, ус дамжуулах хоолой, даралтын насос зэргээс бүрдэнэ. Эргэлтийн ус дамжуулах насосын станцын гарах аманд урсцын хэмжээ, даралтыг шалгах хэмжүүр суурилуулна. Баяжуулах үйлдвэрийн төв байр доторх баяжуулах ба бусад дамжлагад мөн дээрх хэмжих багажийг тохируулж хяналтын өрөөнөөс системийн ажлын байдал болон усны зарцуулалтад хяналт тавина.

БҮ-ийн дэргэд үйлдвэрийн захиргаа, ажилчдын байр байрлах ба дотроо хоолны газар, амрах байр, халуун усны өрөө, амралтын өрөө, сургалтын танхим зэрэг багтана. БҮ-т нийт 35

2026 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөө

орчим хүн ажиллах ба үйлдвэрийн ажиллах хүчний тоо болон дэд бүтцийн байршлаас хамааран үйлдвэр дээр байнгын эмч, сувилагч байх шаардлагагүй байна. Шаардлагатай үед Баянжаргалан сумын эрүүл мэндийн төвөөр үйлчлүүлэхээр төсөлд тусгасан.

БҮ-т ажиллагсдын 80% нь тухайн орон нутгийн ажилчдыг ажиллуулах учир суурин газар байрлан үйлдвэрийн гэрээт тээврийн хэрэгслээр тээвэрлэнэ. Үлдэх 20 % ажилчдын байранд байрлаж ажиллана.

Үйлдвэр нь Дундговь аймгийн Баянжаргалан сумаас 2.5 км зайд байрлах ба босоо тэнхлэгийн автозамаас 1.5 км зайд байрлана. Баяжуулах үйлдвэрээс 8 км зайд төмөр замын ачиж буулгах талбай байрлаж байгаа ба БҮ-ээс гарах жоншны баяжмалыг төмөр замын ачиж буулгах талбай хүртэл авто тээврээр тээвэрлэх ба, ачиж буулгах талбайгаас төмөр замын тээврээр урд хил хүртэл тээвэрлэнэ. Үйлдвэрээс өдөрт 39.2 тн баяжмал гарах ба 7 хоног 1 удаа буюу 276 тн баяжмал болмогц тээвэр хийхээр төлөвлөв. Гадаад тээврийг гэрээт компаниар хийлгэнэ.

Тус баяжуулах үйлдвэрийн цахилгаан хэрэглэгчдийг Дундговь аймгийн Баянжаргалан сумын төвд орших 35/10 кВ-ын дэд станцын 35 кВ-ын ил хуваарилах байгууламжаас 2.5 км урттай 10 кВ-ын өндөр хүчдэлийн цахилгаан дамжуулах шугамыг татаж БҮ-ийн дэргэд 10/0.4 кВ-ын трансформаторын бууруулах дэд станцыг барьж байгуулан үйлдвэрийн хэрэглэгчдийг цахилгаан эрчим хүчээр хангана. Мөн дотооддоо аюул ослын үед хэрэгжүүлэх төлөвлөгөө тоног төхөөрөмжийн техникийн заалтыг боловсруулан мөрдлөг болгон ажиллана

2025 онд 40.0 мян.тн хүдэр баяжуулж нийт 8101.5 сая төгрөгийн борлуулалтын орлого олж, үүнээс 7584.1 сая төгрөгийн үйлдвэрлэл, үйл ажиллагааны зардал гаргаж 517.4 сая төгрөгийн татвар ногдох орлого олохоор төлөвлөсөн.

Үйлдвэрийн бүх төрлийн машин механизмд үзлэг оношилгоо засварыг тогтмол хийж, холбогдох стандартын шаардлагад нийцүүлэх зорилгоор хийлгэж байна. Үйлдвэрийн хогийн цэг, бие засах газруудад ариутгал халдваргүйжүүлэлт хийх ажлын хүрээнд сард бүр хийж гүйцэтгэнэ. Уурхайн тосгоны талбайд байгуулсан ногоон байгууламжийн арчилгаа тордлогоо усалгаа 6-8-р саруудад хийж гүйцэтгэнэ.. Ус хангамжийн гүний худагт усны тоолуурыг баталгаажуулна. Мөн Умард говь гүвээт халхын дундад хээрийн тойргийн сав газрын захиргаатай усны дүгнэлт гаргуулж, аймгийн БОАЖГ-тай газартай гэрээ байгуулан ажиллана. Нийт сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөнд 2004 000 төгрөг зарцуулахаар төлөвлөсөн.

“Хайлуур жоншны хүдрийг гравитацын аргаар баяжуулах үйлдвэр байгуулах төсөл”-ийн талбайн 4 га талбайн хэмжээнд талбайг тойруулан мод, бутны зурвас байгуулна. Зурвасын гадна талаас: 1-р эгнээнд хайлаас модыг 2-3 метрийн зайтай сөөлжүүлэн тарина. 2-р эгнээнд жигд, сухай зэргийн 3-4 настай 40-50 см өргөнтэй суулгацыг 30-50 см-ийн гүн шуудуунд 20-30 см-ийн зайтай тарина

2026 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөө

Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилсан “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөн санаачилсантай холбоотойгоор Говь-Аргатай ХХК өөрийн эзэмшлийн сумын соёлын төвийн гадна 2026 оны намар 500 мод тарихаар төлөвлөлөө. Энэхүү ажлын зардалд 1500 000 төгрөг зарцуулахаар төлөвлөлөө.

Дүйцүүлэн хамгаалах ажлын хүрээнд Монгол улсын Шадар сайд, Байгаль орчин, аялал жуулчлалын сайд, Уул уурхайн хүнд үйлдвэрийн сайд, Хууль зүй, дотоод хэргийн сайд нарийн хамтарсан 167, А/698, А/336, А242 тушаалын дагуу нэгдсэн арга хэмжээг зохион байгуулах тухай Засгийн газрын 2020 -2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт туссан уул уурхайн үйл ажиллагааны улмаас эвдэрч, олон жил орхигдсон 8000 га талбайг нөхөн сэргээх зорилтыг хангах, нөхөн сэргээлтийн ажлыг эрчимжүүлэх ажлын хүрээнд Дундговь аймгийн Баянжаргалан сумын нутагт үйл ажиллагаанд өртөж орхигдсон 5492 м³ талбайд Дундговь аймгийн Баянжаргалан сумын засаг даргын 2024 оны 02-р сарын 26-ны өдрийн 65 тоот албан бичгээр ирүүлсэн саналыг дагуу сонгосон. 2026 онд энэхүү талбайн нөхөн сэргээлтийг бүрэн гүйцэтгэнэ. Эвдэрсэн газарт техникийн нөхөн сэргээлтийн зардалд 2829 000 төгрөг зарцуулахаар төлөвлөсөн.

Тухайн төслийн үйлдвэрлэлийн болон эрчимтэй сөрөг нөлөөллийн бүсэд иргэд, оршин суугчид, айл өрх, байгууллага байхгүй байна. Иймд нүүлгэн шилжүүлэх төлөвлөгөө тусгагдаагүй болно.

“Жонш баяжуулах үйлдвэр байгуулах төсөл”-ийн технологийн үйл ажиллагаанд химийн бодис ашиглахгүй болно.

Орчны хяналт-шинжилгээний хөтөлбөрийг бүрэн хэрэгжүүлэх, батлагдсан арга, аргачлалаар дээжлэлт, хэмжилт хийх, холбогдох нарийвчлал, тохиргоог хангасан багаж тоног төхөөрөмжөөр шинжилгээг хийлгэх, үр дүнг шаардагдах нэгжийн системээр гаргах зэрэг бүхий л үйл ажиллагааг Говь-Аргатай ХХК хариуцах болно. Байгаль орчны хяналт шинжилгээг тус компанийн байгаль орчны мэргэжилтэн хариуцан гүйцэтгэх эсвэл мэргэжлийн байгууллагатай хамтран ажиллана. "Говь-Аргатай ХХК хайлуур жоншны баяжуулах үйлдвэр нь үйл ажиллагааныхаа явцад байгаль орчинд учруулж буй нөлөөлөл, түүний хэмжээ, цар хүрээ, байгаль орчны бүрэлдэхүүн хэсгүүдэд гарч буй өөрчлөлтийг хянаж, байгаль орчныг хамгаалах ажлын үр дүнд тулгуурлан цаашид авах арга хэмжээг нарийвчлан төлөвлөх зорилгоор орчны хяналт, шинжилгээний хөтөлбөрт тусгасан арга хэмжээг бүрэн хэрэгжүүлэх шаардлагатай. Орчны хяналт-шинжилгээний хөтөлбөрийн үр дүнд байгаль орчны төлөв байдалд өөрчлөлт орох, бохирдлын хэмжээ байгаль орчны стандарт, нормоос хэтэрч илрэх тохиолдолд мэргэжлийн байгууллагад яаралтай хандаж, холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлнэ. Агаарын чанарт 3 цэгт, хөрсөн бүрхэвч 2, эргэлтийн усан сангийн 1 цэгт тус бүр хэмжилт дээжлэлтийг хийхээр төлөвлөсөн. Нийт зардалд 1288.800 төгрөг зарцуулахаар төлөвлөлөө.

Нийт хийгдсэн ажлуудыг нэгтгэн дүгнэж өмнө 9-р сарын уулзалтаар өгсөн саналыг хэрэгжүүлж эхэлсэн талаар Баянжаргалан сумын иргэд, Дундговь аймгийн Байгаль орчны

2026 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөө

газар, Мэргэжлийн хяналтын газруудад танилцуулга хийхээр төлөвлөсөн. Мөн тухайн жилийн биелэлтийн тайланг 2026 оны 11-р сарын 1-ны өдөр аймгийн байгаль орчны газар болон Баянжаргалан сумын ЗДТГ-т хүргэн өгөхөөр төлөвлөсөн.

Хүснэгт 18. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний нэгдсэн хүснэгт

№	Зардлын утга	Нийт зардал, төг
1	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний ажлын зардал	12735
2	Соёлын өвийн хамгаалах арга хэмжээний төлөвлөлт	300
3	Дүйцүүлэн нөхөн сэргээлт	2829
4	Тэрбум мод арга хэмжээний төлөвлөгөө	1500
5	Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөө	2500
6	Хог хаягдлын менежментээр хийгдэх ажлын зардал	7108.0
7	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн зардал	1288.8
8	Удирдлага зохион байгуулалтын ажлын зардал	3000.0
9	Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг тайлагнах хуваарь, зардлын задаргаа	500.0
2026 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний нийт зардлын дүн		31760 800

2026 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд нийт **31760 800** төгрөг зарцуулахаар төлөвлөөд байна. Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээлтийн барьцаа мөнгө болгож **15880 400** төгрөгийг Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9,15 дахь заалтад зааснаар Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2019 оны 10 дугаар сарын 29-ны өдрийн А-618 тоот тушаалын дагуу Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээлтийн баталгааны тусгай дансанд 17486 800 төгрөгийг 2026 оны 05-р сарын 23-ны өдөр байршуулсан. Хавсралтаар төлбөрийн баримтыг хавсаргав.

2026 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөө

ХААН БАНК

Огноо/Date: 2026-05-23 17:51:39

Шилжүүлгийн мэдээлэл/Transaction information
 Журналын /Journal No: 31963312
 Гүйлгээний дугаар /PoId: 0

Системийн огноо/System Date: 2026-05-23 17:51:23

Дт	IBAN/Дансны/Картын дугаар IBAN/Account/Card number	Нэр/Name	Дүн/Amount	Ханш/Rate
	5452101349	ГОВЬ АРГАТАЙ ДЕВЕЛОПМЕНТ	17,486,800.00 MNT	1.00

Кт	Банкны дугаар/Branch No MOFUMNUB	Банкны нэр/Bank Name ТӨРИЙН САН		
	IBAN/Дансны/Картын дугаар IBAN/Account/Card Number MN190090 000900013406	Нэр/Name	17,486,800.00 MNT	1.00

Гүйлгээний утга/Transaction description:
 EB-3433868 НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН БАРЬЦАА

Харилцагч танд баярлалаа./Thank you to our customers

Гүйлгээний баримтыг баталгаажуулсан/Transaction statement verified:

 Салбар, тооцооны төв/Branch, sub-branch:

 Гарын үсэг/Signature:

 Тамга/Stamp:

____ Он/Year (YYYY) ____ Сар/Month (MM) ____ Өдөр/Day (DD)